



ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ДҮРЭМ

**Улаанбаатар хот
2013 он**

ХУУЛЬЧДЫН АНХДУГААР ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 10 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2 дахь заалт, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 3.1 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт, Хуульчдын анхдугаар их хурлын хуралдааны дэгийн 15.1, 19.1-т заасныг тус тус үндэслэн Хуульчдын Их хурлаас ТОГТООХ нь:

1.“Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.“Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм”-ийг буцаан хэрэглэхгүй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Б.БАТЦЭРЭН

АГУУЛГА

Нэгдүгээр анги.	Нийтлэг үндэслэл	4
Нэгдүгээр бүлэг.	Ерөнхий зүйл	4
Хоёрдугаар анги.	Хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч хуульч	7
Хоёрдугаар бүлэг.	Хуульч үйлчлүүлэгчтэйгээ харилцах	7
Гуравдугаар бүлэг.	Хууль зүйн зөвлөгөө.....	14
Дөрөвдүгээр бүлэг.	Өмгөөллийн үйлчилгээ	15
Тавдугаар бүлэг.	Үйлчлүүлэгч бус этгээдтэй харилцах	17
Зургаадугаар бүлэг.	Өмгөөллийн нөхөрлөл	18
Долоодугаар бүлэг.	Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа	20
Наймдугаар бүлэг.	Хууль зүйн үйлчилгээний тухай сурталчилгаа	20
Гуравдугаар анги.	Прокурор	20
Есдүгээр бүлэг.	Прокурорын хараат бус, зарчимч байдал	20
Аравдугаар бүлэг.	Прокурорын ашиг сонирхлын зөрчил	23
Арван нэгдүгээр бүлэг.	Прокурорын албан үүргээс бусад үйл ажиллагаа ба хувийн амьдрал	24
Арван хоёрдугаар бүлэг.	Хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчтой харилцах	26
Арван гуравдугаар бүлэг.	Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	28
Арван дөрөвдүгээр бүлэг.	Прокурорын улс төрийн үйл ажиллагаа	30
Дөрөвдүгээр анги.	Шүүгч	30
Арван тавдугаар бүлэг.	Шүүх эрх мэдлийн бие даасан, зарчимч, төвийг сахих байдал	30
Арван зургаадугаар бүлэг.	Шүүгчийн ашиг сонирхол	33
Арван долоодугаар бүлэг.	Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа ба хувийн амьдрал	34
Арван наймдугаар бүлэг.	Шүүгчийн улс төрийн үйл ажиллагаа	37
Тавдугаар анги.	Хуульчийн мэргэжлийн зарчимч байдал	37
Арван есдүгээр бүлэг.	Хуульч Хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцох	38
Хорьдугаар бүлэг.	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, хариуцлага	39

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ДҮРЭМ

Хуульч бид

- Үндсэн хуульт ардчиллын үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шударга ёсыг хангах, хуулийн засаглалыг тогтооход хараат бус хуульч мэргэжилтэн чухал болохыг бүрнээ ухамсарлаж,

- үйлчлүүлэгчийнхээ эрх, ашиг сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалах хуульч; нийтийн ашиг сонирхлыг төлөөлж, бодит үнэн, шударга ёсыг эрэлхийлэх прокурор; аливаа хэрэг, маргааныг хараат бус, шударга, төвийг сахиж хянан шийдвэрлэх шүүгч; хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэн түгээн дэлгэрүүлэгч мэргэжилтэн болохоо нотлон,

- шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, иргэдэд хүртээмжтэй байлгах, хуулийн засаглалыг төгөлдөржүүлэхийг байнга эрмэлзэж,

- мэргэжилдээ үнэнч, зарчимч, ёс зүйтэй байж олон нийтийн итгэлийг хадгалахаа илэрхийлж энэхүү дүрмээр өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хариуцлага хүлээх үндсийг тогтоож байна.

НЭГДҮГЭЭР АНГИ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 дүгээр зүйл.Дүрмийн зорилго, үйлчлэх хүрээ

1.Энэхүү дүрмийн зорилго нь хуульчийн баримтлах нийтлэг зарчим, ёс зүйн хэм хэмжээ, хуульчийн тусгайлсан үүргийг тогтоох, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн зарчимч байдлыг хангах, хуульчийн нэр хүнд, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

2.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч хуульч, прокурор, шүүгч, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий бусад этгээдийн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд энэ дүрэм үйлчилнэ.

1.2 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны хууль зүйн үндэс

1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, үүргийг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж болон энэ дүрмээр тодорхойлно.

1.3 дугаар зүйл.Нэр томъёоны тодорхойлолт

1.Энэ дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.1.“хараат бус байдал” гэж хуульд зааснаас бусад аливаа зүй бус нөлөөлөл эсхүл хяналтаас ангид байхыг;

1.2.“ур чадвартай байх” гэж хууль зүйн мэдлэгээ практикт хэрэглэх чадвар, дадал болгон хөгжүүлснийг;

1.3.“хамаарал бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасныг;

1.4.“зарчимч байдал” гэж хууль болон энэ дүрэмд заасан зарчмаа хэлбэрэлтгүй баримталж, үнэнч, шударга, ёс зүйн өндөр шаардлага хангасан байхыг;

1.5.“үндэслэлтэйгээр итгэх” гэж тодорхой нөхцөл байдалд хуульч хувийн бодит итгэл дээр тулгуурлан мэргэжлийн үйл ажиллагаа явуулж, үүнийгээ үндэслэлтэйгээр тайлбарлахыг;

1.6.“мэдээлэлтэй зөвшөөрөл” гэж хуульчаас санал болгосон үйл ажиллагаанаас үүсч болох эрсдэл, хууль зүйн үр дагавар болон бусад хувилбарын талаар хангалттай мэдээлэл, тайлбар өгснөөр үйлчлүүлэгч тухайн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн илэрхийлэлийг;

1.7.“хууль зүйн үйлчилгээ” гэж шүүгч болон прокуророос бусад хуульчаас үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд явуулж байгаа хууль зүйн зөвлөгөө, лавлагаа өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах, хянах, батлах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, төлөөлөх, өмгөөлөх, эвлэрүүлэн зуучлах зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг;

1.8.“өмгөөлөгч” гэж шүүхэд төлөөлөх эрхээ хуульд заасан журмын дагуу нээлгэсэн бөгөөд үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг, маргаан хянан шийдвэрлэх байгууллагад түүнийг төлөөлж өмгөөллийн үйлчилгээ үзүүлж буй хуульчийг;

1.9.“зохисгүй байдал” гэж хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, энэ дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг;

1.10.“төвийг сахих” гэж хэрэг, маргааны аль нэг талыг ялгаварлан гадуурхахгүй, түүнчлэн шүүгчийн зүгээс аливаа хууль зүйн асуудал, түүнийг шийдвэрлэхтэй холбоотой талуудын байр суурийг бүрэн сонсох, бодож эргэцүүлэх, хүлээн зөвшөөрөх эрмэлзлэлтэй байхыг.

1.4 дүгээр зүйл.Хуульчийн баримтлах нийтлэг зарчим

1.Хуульч мэргэжлийн үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтална:

- 1.1.хүний эрхэм чанарыг хүндлэх;
- 1.2.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- 1.3.шударга ёсыг баримтлах;
- 1.4.хууль дээдлэх;
- 1.5.ялгаварлан гадуурхахгүй байх;
- 1.6.зарчимч байх;
- 1.7.бодитой, ухаалаг хандах;
- 1.8.хараат бус байх;
- 1.9.шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хүндэтгэх, хамгаалах;
- 1.10.нууцыг хадгалах, хамгаалах;
- 1.11.ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;
- 1.12.мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх.

1.5 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн хараат бус байдал

1.Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаагаа хараат бус эрхлэх төдийгүй бусад хуульчийн хараат бус байдалд хүндэтгэлтэй хандана.

1.6 дугаар зүйл.Мэргэжлийн шаардлага хангасан байх

1.Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж, нямбай, хариуцлагатай ажиллана.

2.Хуульч нь мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахын төлөө мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлж, өөрийгөө байнга хөгжүүлэх үүрэгтэй бөгөөд хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, эрдэм шинжилгээний бүтээлийг судалж байвал зохино.

3.Хуульч нь мэргэжлийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, тодорхой багц цаг хангана.

4.Хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цаг хангаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дөрвөөс дээш жил мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй бол тухайн хуульч мэргэжлийн шаардлага хангасан эсэхэд эргэлзэх үндэслэл болно.

1.7 дугаар зүйл.Хичээл зүтгэл гаргах

1.Хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд хүчин чармайлт гаргаж, шуурхай, зохион байгуулалттай ажиллана.

1.8 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үүргээ чухалчлах

1.Хуульч нь хуульчийн мэргэжлийн үүргээс бусад үйл ажиллагаа болон хувийн амьдралдаа мэргэжлийн үүрэгтэйгээ зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ.

1.9 дүгээр зүйл.Хувийн дотно харилцаанаас зайлсхийх

1.Хуульч нь өөрийн мэргэжлийн үүргийн дагуу оролцож байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчтой хувийн дотно харилцаа үүсгэхээс зайлсхийх бөгөөд хэрэв тийм харилцаа үүсгэсэн бол татгалзан гарна.

1.10 дугаар зүйл.Нууц хадгалах

1.Хуульч мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, эсхүл хувь хүний нууцыг чанд хадгална.

1.11 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үүрэгтэй холбоотой мэдээлэл

1.Хуульч нь өөрийн мэргэжлийн үүрэгтэй холбоотой худал, төөрөгдүүлсэн агуулгатай, хуульчийн мэргэжлийн нэр хүндийг гутаасан, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх мэдээлэл хийхийг хориглоно.

1.12 дугаар зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй харилцах

1.Хуульч нь шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр томилогдож болох иргэнд аливаа байдлаар нөлөөлөх эсхүл шийдвэр гаргасных нь төлөө шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сайшаах, буруутгахыг хориглоно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хориглолт нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хууль бус үйлдлийг мөрдөн шалгах, яллахад үйлчлэхгүй.

1.13 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үүргээс бусад үйл ажиллагаа

1.Хуульч мэргэжлийн үүргээ бодитой, шударгаар хэрэгжүүлэхэд саад болохгүй, хараат бус, зарчимч байдлыг нь алдагдуулахгүй тохиолдолд дараах үйл ажиллагаанд оролцохыг эрмэлзэнэ:

- 1.1.хууль зүйн хичээл заах, сургалт явуулах;
- 1.2.судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх;
- 1.3.хуулийг боловсронгуй болгох, эрх зүйг шинэтгэхэд чиглэсэн үйл ажиллагаа;
- 1.4.Хуульчдын холбооны үйл ажиллагаа;
- 1.5.иргэний боловсролын, сайн үйлийн, эсхүл эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулсан нийтэд тустай үйл ажиллагаа;
- 1.6.нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулах талаар бусад хуульчийг зөвлөн дэмжих.

2.Хуульч нь хууль эсхүл энэ дүрмээр хориглоогүй аливаа үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

3.Хуульч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд (цаашид “хуульчийн зөвшөөрөлгүй этгээд” гэх)-д хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад туслахыг хориглох бөгөөд хуульчийн зөвшөөрөлгүй этгээд ийм үйл ажиллагаа явуулж байгааг мэдсэн бол энэ талаар Хуульчдын холбоонд мэдэгдэнэ.

1.14 дүгээр зүйл.Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглах

1.Хуульч нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглахдаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль, энэ дүрмийг зөрчихийг хориглоно.

1.15 дугаар зүйл.Өөрийн удирдлага дахь этгээдэд шаардлага тавих

1.Хуульч өөрийн удирдлага дахь этгээдийн үйл ажиллагаа хууль болон энэ дүрмээр хуульчид хүлээлгэсэн үүрэгт нийцсэн байх талаар тухайн этгээдийг сургаж, хяналт, шаардлага тавьж ажиллана.

ХОЁРДУГААР АНГИ ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ХУУЛЬЧ

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧТЭЙГЭЭ ХАРИЛЦАХ

2.1 дүгээр зүйл.Хууль зүйн үйлчилгээний хүрээ

1.Хуульч нь хууль зүйн үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх)-ний зорилго, хүрээ, шийдлийг тодорхойлохдоо үйлчлүүлэгчийн хүсэл зориг, ашиг сонирхолд үндэслэх бөгөөд үйлчилгээний зорилго, арга замын талаар үйлчлүүлэгчтэй зөвлөлдөнө. Хуульч нь үйлчлүүлэгчийн шийдвэрт хүндэтгэлтэй хандах бөгөөд түүнд дарамт, шахалт үзүүлж болохгүй.

2.Хуульч үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс хууль болон гэрээгээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд өөрөө санаачлан үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцэх мэргэжлийн үйл ажиллагаа явуулж болно.

3.Хуульч зайлшгүй нөхцөл байдлын улмаас үйлчилгээний хүрээг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл үйлчлүүлэгчээс мэдээлэлтэй зөвшөөрөл авна.

4.Хуульч зөвхөн үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй зөвшөөрлөөр хэрэг, маргааныг эвлэрүүлэн шийдвэрлүүлэх ажиллагааг явуулна. Хуульч гэмт хэрэгт буруутгагдаж байгаа үйлчлүүлэгчдээ гэм буруугаа хүлээх, мэдүүлэг өгөх эсэх болон хуульд заасан бусад эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөсний дараа үйлчлүүлэгчийн гаргасан мэдээлэлтэй зөвшөөрлийн дагуу ажиллана.

5.Хуульчийн хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа үйлдэл нь тухайн үйлчлүүлэгчийн улс төр, эдийн засаг, нийгэм эсхүл ёс суртахууны үзэл санаа, үйл ажиллагааны илэрхийлэл болохгүй.

6.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх нэрийн дор хуульч нь улс төр, нийгэм, эдийн засаг, ёс суртахууны үзэл санааг сурталчлах, эсхүл энэ төрлийн үйл ажиллагааг явуулахыг хориглоно.

7.Үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээний хүрээнд хийгдэж болох аливаа үйлдэл, эс үйлдэхүйн хууль зүйн үр дагавар, эрсдэл, хэрэглэгдэх хууль тогтоомжийн утга санаа, хэрэглээг хуульч тайлбарлаж өгнө.

8.Хуульч залилан зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг үйлчлүүлэгчид зөвлөх эсхүл үйлчлүүлэгч болон бусдын ийм агуулга бүхий саналыг дэмжихийг хориглоно.

9.Үйлчлүүлэгчээс өөрийн ашиг сонирхлыг өөр хуульчтай хамтран хамгаалуулах хүсэлт гаргасан бол хуульч тухайн хуульчтай хууль зүйн үйлчилгээний хүрээ, зорилго, үүргийн хуваарилалт, тактикийн асуудлаар зөвлөлдөж хамтран ажиллана.

10.Хуульч өөр хуульчийн ажиллаж байсан хэрэг, маргаанд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хүсэлт хүлээн авбал энэ тухай тухайн хуульчид мэдэгдсэний дараа үйлчилгээг үзүүлнэ.

2.2 дугаар зүйл.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ

1.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх харилцаа нь үйлчлүүлэгчийн хүсэлт, гэрээнд үндэслэнэ.

2.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг бичгээр байгуулна.

3.Хуульч нь хуульчаас тухайн тодорхой асуудлаар үзүүлвэл зохих мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэлээр мэргэжлийн үйлчилгээ үзүүлж чадаагүйн улмаас үйлчлүүлэгчийн өмнө хүлээх хариуцлагыг хязгаарласан гэрээ байгуулахыг хориглоно.

2.3 дугаар зүйл.Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоотой байх

1.Хуульч нь үйлчлүүлэгчтэйгээ тогтмол, ойлгомжтой харилцаа холбоотой байх бөгөөд дараах үүрэг хүлээнэ:

1.1.хууль эсхүл энэ дүрэмд заасны дагуу мэдээлэлтэй зөвшөөрөл шаардлагатай аливаа шийдвэр, нөхцөл байдлын талаар үйлчлүүлэгчид мэдэгдэх;

1.2.хууль зүйн үйлчилгээний зорилгод хүрэх арга замын талаар үйлчлүүлэгчтэй зөвлөлдөх;

1.3.үйлчилгээний явцын талаар тухай бүрт нь үйлчлүүлэгчид мэдээлэх;

1.4.үйлчлүүлэгчийн мэдээлэл хүссэн үндэслэл бүхий хүсэлтийг шуурхай хангах;

1.5.үйлчлүүлэгч энэ дүрэм болон хуулиар хориглосон үйлчилгээ авахыг хүссэн тохиолдолд хуульч нь өөрийн үйл ажиллагааны хязгаарлалтын талаар тайлбарлах.

2.Үйлчлүүлэгчээс хууль зүйн үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргахад хуульч тухайн асуудал, нөхцөл байдал, үр дагаврын талаар шаардлагатай хэмжээнд тайлбарлаж зөвлөнө.

2.4 дүгээр зүйл.Хууль зүйн үйлчилгээний хөлс, зардал

1.Хуульч үйлчилгээний хөлс, зардлыг үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцож тогтооно.

2.Хуульч нь үндэслэлгүй хөлс, зардал тогтоох, авахыг хориглоно. Үйлчилгээний хөлсийг тодорхойлохдоо дараах хүчин зүйлийг харгалзана:

2.1.үйлчилгээний хүрээ болон хүрэх үр дүн;

2.2.үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хугацаа, ажил, ур чадвар болон холбогдох асуудлын онцлог, хүндрэл;

2.3.хуульчийн мэдлэг, ур чадвар, туршлага, нэр хүнд;

2.4.тухайн үйлчилгээг үзүүлснээр бусад мэргэжлийн үйл ажиллагаа эхлэхэд нь саад учруулах магадлал;

2.5.үйлчлүүлэгчийн төлбөрийн чадвар;

2.6.үйлчлүүлэгчээс тогтоосон эсхүл нөхцөл байдлаас хамаарсан хугацааны хязгаарлалт, орон зайн алслалт;

2.7.үйлчлүүлэгчтэй тогтоосон мэргэжлийн харилцааны агуулга, давтамж болон хугацаа;

2.8.хөлсийг урьдчилан тогтоох эсхүл үйлчилгээний үр дүнгээс хамааруулах эсэх;
2.9.зайлшгүй бусад хүчин зүйл.

3.Хуульч нь үйлчилгээний хүрээ, хөлс, зардлын хэмжээ, тэдгээрийг тодорхойлох аргын талаарх саналаа үйлчлүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй бөгөөд мэдэгдлийг бичгээр үйлдвэл зохимжтой. Хөлс, зардлын хэмжээг өөрчлөх бол үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

4.Хууль эсхүл энэ зүйлийн 7 дахь хэсэгт хориглосноос бусад тохиолдолд хөлсийг тухайн үйлчилгээний үр дүнгээс хамааруулан гэрээгээр тогтоож болох бөгөөд үүнийг хамааралт хөлс гэнэ.

5.Хамааралт хөлсний дээд хэмжээ тухайн үйлчилгээний үр дүнгийн 30 хувиас илүүгүй байна.

6.Хамааралт хөлс авч үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон бол гэрээнд дараах нөхцлийг заавал тусгана:

6.1.хэрэг, маргааныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэсэн, эвлэрүүлэн зуучлах, хялбаршуулсан журмаар, анхан, давж заалдах, эсхүл хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн тохиолдолд хуульчид ногдох хувь;

6.2.хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардлыг эцэслэн шийдвэрлэсэн үнийн дүнгээс гаргуулах эсэх.

7.Дараах төрлийн хууль зүйн үйлчилгээ үзүүлэхэд хамааралт хөлс тогтоохыг хориглоно:

7.1.эцэг буюу эх тогтоолгох, тэтгэлэг, тэтгэмж, тэтгэвэр тогтоолгох, гэрлэлт цуцлах, гэр бүлийн дундын өмчийн маргааныг шийдвэрлэх;

7.2.гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагчийг өмгөөлөх.

8.Хуульч нь хууль зүйн үйлчилгээний орлогоо зохих журмаар мэдүүлж, түүнд ногдох татвараа үнэнч шударгаар төлнө.

2.5 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал

1.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хуульч нь үйлчлүүлэгчээс мэдээлэлтэй зөвшөөрөл өгсөн, агуулгаараа нууцад хамаарахгүй, олон нийтэд нэгэнт ил болсон эсхүл үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд зайлшгүй задруулах шаардлагатай мэдээллээс бусад үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг задруулахыг хориглоно.

2.Хуульч үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг зөвхөн дараах тохиолдолд зайлшгүй шаардлагатай хэмжээнд задруулж болно:

2.1.хүний амь нас хохирох эсхүл бие махбодид ноцтой хохирол учрахаас сэргийлэх;

2.2.үйлчлүүлэгч хуульчийн үйлчилгээг ашиглан бусдын өмчлөх эрх, санхүүгийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах нь тодорхой байгаа нөхцөлд гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх;

2.3.үйлчлүүлэгч хуульчийн үйлчилгээг ашиглан үйлдсэн гэмт хэргийн улмаас бусдын өмчлөх эрх, санхүүгийн ашиг сонирхолд ноцтой хохирол учрахаас сэргийлэх буюу учирсан хохирлыг багасгах, арилгах;

2.4.хуульч энэ дүрэм эсхүл хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн гэж өөрөө буруутгагдаж байгаа тохиолдолд тухайн асуудлыг шийдвэрлэх;

2.5.хуульч ажлын байраа сольсон эсхүл өмгөөллийн нөхөрлөлийн бүрэлдэхүүн, өмчлөлд өөрчлөлт орсноос үүдэн гарах ашиг сонирхлын зөрчлийг илрүүлж шийдвэрлэх. Энэ заалтын дагуу задруулахыг зөвшөөрсөн мэдээлэл нь хууль зүйн үйлчилгээний нууцыг хамгаалсан хуулийг зөрчиж үйлчлүүлэгчид хохирол учруулж болохгүй;

2.6. хууль эсхүл энэ дүрмээр зөвшөөрсөн.

3.Хуульч нь үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд сэргөөр ашиглахыг хориглоно.

4.Хуульч нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг задруулахаас сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээ авна.

2.6 дугаар зүйл.Ашиг сонирхлын зөрчил

1.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хуульч үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчид ашиг сонирхлын зөрчил бий болгохоор байвал үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

2.Ашиг сонирхлын зөрчил гэдэгт дараах тохиолдлын аль нэгийг ойлгоно:

2.1.нэг үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх нь тухайн хуульчийн бусад үйлчлүүлэгчийнх нь шууд эсрэг байх;

2.2.урьдын үйлчлүүлэгч, бусад үйлчлүүлэгч, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн хуульчийн үүрэг, эсхүл хуульчийн хувийн ашиг сонирхол нь түүний үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээг хязгаарлах бодит эрсдэл бий болох.

3.Хуульч нь ашиг сонирхлын зөрчил үүссэн ч дараах бүх нөхцөл хангагдсан бол үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж болно:

3.1.тухайн үйлчилгээг хуулиар хориглоогүй;

3.2.хуульч нь тухайн үйлчлүүлэгч бүрт хангалттай мэдлэг, ур чадвар, хичээл зүтгэл гарган зохих үйлчилгээ үзүүлж чадна гэдэгт үндэслэлтэйгээр итгэж байгаа;

3.3.хуульчийн нэг үйлчлүүлэгч нөгөө үйлчлүүлэгчийн эсрэг гомдол, нэхэмжлэл гаргаж нэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй;

3.4.ашиг сонирхол нь зөрчилдөж байгаа үйлчлүүлэгч бүр мэдээлэлтэй зөвшөөрөл бичгээр өгсөн.

4.Хоёр буюу түүнээс дээш үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж буй хуульч нь үйлчлүүлэгчдийн нэхэмжлэлүүдийг нийтэд нь эвлэрүүлэн шийдвэрлэхэд, эсхүл гэмт хэрэгт гэм буруугаа хүлээж буй тухай тайлбар нийтэд нь гаргахад үйлчлүүлэгч тус бүрийн мэдээлэлтэй зөвшөөрлийг бичгээр авна. Хуульч эвлэрүүлэн шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын оролцоо, холбогдох нэхэмжлэл, тайлбарын агуулгыг үйлчлүүлэгч бүрт мэдэгдэнэ.

2.7 дугаар зүйл.Санхүүгийн ашиг сонирхлын зөрчил

1.Хуульч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харш эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөртөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээдэд аливаа хэлбэрээр шилжүүлэн авахыг хориглоно.

2.Дараах бүх нөхцөл хангагдсанаас бусад тохиолдолд хуульч нь үйлчлүүлэгчтэйгээ бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

2.1.бизнесийн үйл ажиллагааны гэрээний нөхцөл нь үйлчлүүлэгчийн хувьд шударга, үндэслэлтэй, ойлгогдохуйц бөгөөд энэ талаар үйлчлүүлэгчид бичгээр мэдэгдсэн;

2.2.бизнесийн үйл ажиллагааны талаар хараат бус хууль зүйн зөвлөгөө авах нь зүйтэй талаар үйлчлүүлэгчид бичгээр зөвлөж, тийм боломж олгосон;

2.3.үйлчлүүлэгч бизнесийн үйл ажиллагаан дахь хуульчийн үүрэг болон тухайн үйл ажиллагааны үндсэн нөхцөлийн талаар мэдээлэлтэй зөвшөөрлийг бичгээр өгсөн.

3.Хуульч нь үйлчлүүлэгчээс үйлчилгээний хөлс, зардлаас гадна бэлэг, шан харамж шаардах, шууд эсхүл шууд бусаар дарамт үзүүлэхийг хориглоно.

4.Дор дурдсанаас бусад тохиолдолд хуульч нь үйлчлүүлэгчид хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой санхүүгийн туслалцаа үзүүлж болохгүй:

4.1.хамааралт хөлс авахаар тохирсон бол хуульч тухайн хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардлыг урьдчилан төлөх;

4.2.төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа хуульч тухайн үйлчлүүлэгчийнхээ нэрийн өмнөөс хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг төлөх.

2.8 дугаар зүйл.Өмгөөллийн нөхөрлөлтэй холбоотой ашиг сонирхлын зөрчил

1.Хуульч нь энэ дүрмийн 2.6 дугаар зүйлд заасан үндэслэлээр үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж болохгүй бол түүнтэй нэг өмгөөллийн нөхөрлөлд харьяалагддаг бусад хуульч тухайн үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Өмгөөллийн нөхөрлөлийн бусад хуульч гэдэгт одоо ажиллаж байгаа эсэхээс үл хамааран ашиг сонирхлын зөрчил бий болох үед тухайн нөхөрлөлд ажиллаж байсан хуульчийг ойлгоно.

2.Хуульч өөрөө эсхүл урьд ажиллаж байсан өмгөөллийн нөхөрлөл нь үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгчийн эсрэг ашиг сонирхол бүхий этгээдэд тухайн хэрэг, маргаантай холбоотой асуудлаар үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Энэ хориглолт нь тухайн хуульчийн ажиллаж байгаа өмгөөллийн нөхөрлөлийн бусад хуульчид мөн адил хамаарна.

3.Хуульч энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан ашиг сонирхлын зөрчил бий болсон ч энэ дүрмийн 2.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүх нөхцөл хангагдаж байвал үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж болно.

4.Хуульч өмгөөллийн нөхөрлөл байгуулах эсхүл өөрчлөн байгуулахдаа өөрийн үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ зөрчих эсхүл ашиг сонирхлын зөрчилд орохоос сэргийлнэ.

2.9 дүгээр зүйл.Төрийн албан хаагчтай холбоотой ашиг сонирхлын зөрчил

1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд ажиллаж байгаа эсхүл урьд ажиллаж байсан хуульч нь холбогдох хууль болон энэ дүрмийн 2.6-2.8 дугаар зүйлд захирагдана.

2.Хуульд өөрөөр заагаагүй бол хуульч нь төрийн албанд ажиллаж байхдаа мэдсэн төр, байгууллага эсхүл хувь хүний нууцад хамаарах мэдээллийг тухайн этгээдийн ашиг сонирхлын эсрэг ашиглах, эсхүл түүнтэй ашиг сонирхлын зөрчил бүхий этгээдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлж болохгүй.

3.Төрийн албанд ажиллаж байгаа хуульч дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

3.1.төрийн албанд орохоосоо өмнө хууль зүйн үйлчилгээ үзүүлж байсан үйлчлүүлэгчтэй холбоотой асуудал шийдвэрлэхэд оролцох;

3.2.энэ дүрмийн 2.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд төрийн албыг төлөөлж биечлэн оролцсон асуудлын эсрэг тал, түүний хуульчтай ажилд орох тухай хэлэлцэх.

2.10 дугаар зүйл.Хөндлөнгийн этгээд байсан хуульч

1.Хуульч урьд нь шүүгч, арбитрч, эвлэрүүлэн зуучлагч, бусад хөндлөнгийн этгээдийн хувьд хэрэг, маргааныг шийдвэрлэхэд оролцсон бол тухайн хэрэг, маргааны аль нэг тал, түүний хуульчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх, ажилд орох тухай хэлэлцэхийг хориглоно.

2.Хуульч урьд нь шүүгч, арбитрч, эвлэрүүлэн зуучлагч, бусад хөндлөнгийн этгээдийн туслахын хувьд хэрэг, маргааныг шийдвэрлэхэд оролцсон бол тухайн хэрэг маргааны аль нэг тал, түүний хуульчтай ажилд орох тухай хэлэлцэж болох бөгөөд энэ талаар шүүгч, арбитрч, эвлэрүүлэн зуучлагч, бусад хөндлөнгийн этгээдэд мэдэгдэнэ.

3.Өмгөөллийн нөхөрлөлийн хуульчдын нэг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж болохгүй тохиолдолд бусад хуульч нь тухайн үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

4.Арбитрын бүрэлдэхүүнд нэг талын сонголтоор орсон арбитрч тухайн талд дараа нь үйлчилгээ үзүүлэхэд энэ зүйл хамаарахгүй.

2.11 дүгээр зүйл.Байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх

1.Байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа хуульч (цаашид “байгууллагын хуульч” гэнэ) нь зөвхөн тухайн байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлж, түүний ашиг сонирхлыг хамгаална.

2.Байгууллагын хуульч нь тухайн байгууллагын албан тушаалтан, ажилтан, эсхүл бусад этгээдийн зүгээс байгууллагын өмнө хүлээсэн үүрэг эсхүл хуулиар хүлээсэн байгууллагын үүргийг зөрчсөний улмаас байгууллагад ноцтой хохирол учирч болзошгүй тохиолдолд байгууллагын ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай арга хэмжээ авна. Хуульч нь тухайн нөхцөл байдлаас хамаарч байгууллагын дээд шатны эсхүл хамгийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа этгээдэд асуудлыг мэдэгдэнэ.

3.Байгууллагын хуульч нь дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд зөрчлийн улмаас байгууллагад ноцтой хохирол учрахаас сэргийлэх зорилгоор энэ дүрмийн 2.5 дугаар зүйлд зааснаас үл хамааран үйлчилгээтэй холбоотой мэдээллийг зайлшгүй шаардлагатай хэмжээнд задруулж болно:

3.1.хуульч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагатай арга хэмжээг авсан боловч байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг шуурхай шийдвэрлэх талаар зохих арга хэмжээг аваагүй эсхүл авахаас татгалзсан;

3.2.хуульч нь тухайн зөрчлийн улмаас байгууллагад ноцтой хохирол гарцаагүй учирна гэдэгт үндэслэлтэйгээр итгэж байгаа.

4.Хуульч нь энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасны дагуу авсан арга хэмжээний улмаас гэрээ цуцлагдсан, эсхүл өөрөө тус байгууллагад үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан бол байгууллагын хамгийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа этгээд тийнхүү гэрээ нь цуцлагдсан, эсхүл татгалзсан тухай мэдэх хүртэл шаардлагатай арга хэмжээ авна.

5.Байгууллагын хуульч байгууллагад харьяалагдах албан тушаалтан, ажилтан, бусад этгээдийн ашиг сонирхол байгууллагынхтай зөрчилдөх талаар мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан тохиолдолд эдгээр этгээдэд байгууллагын өмнө хүлээсэн үүргийн талаар тайлбарлана.

6.Энэ дүрмийн 2.6 дугаар зүйлийг зөрчөөгүй тохиолдолд байгууллагын хуульч нь байгууллагад харьяалагдах албан тушаалтан, ажилтан, бусад этгээдэд хуулийн хүрээнд хууль зүйн үйлчилгээ үзүүлж болно. Хуульч энэ үйлчилгээг үзүүлэхдээ энэ дүрмийн 2.6 дугаар зүйлд заасны дагуу байгууллагаас мэдээлэлтэй зөвшөөрөл авах бөгөөд энэ тохиолдолд тухайн үйлчилгээ авах гэж байгаа этгээдээс бусад зохих албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авна.

7.Хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээгээр байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа хуульчид энэ зүйлийн 2-6 дугаар хэсэг мөн адил хамаарна.

2.12 дугаар зүйл.Чадамж нь хязгаарлагдсан үйлчлүүлэгч

1.Үйлчлүүлэгч нь 18 насанд хүрээгүй, бие махбодийн эсхүл сэтгэл зүйн байдал зэрэг шалтгааны улмаас хууль зүйн үйлчилгээтэй холбоотой зохих шийдвэрийг бие даан гаргах чадамж нь хязгаарлагдсан тохиолдолд хуульч тухайн үйлчлүүлэгчтэй тогтоосон хуульч болон үйлчлүүлэгчийн харилцаагаа хэвийн хадгална.

2.Хуульч үйлчлүүлэгчийнх нь шийдвэр гаргах чадамж хязгаарлагдаж, өөрийн эрх, ашиг сонирхлыг зохих ёсоор хамгаалж чадахгүйн улмаас түүнд бие махбодийн, санхүүгийн эсхүл бусад хохирол гацаагүй учирна гэдэгт үндэслэлтэйгээр итгэж байгаа бол үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах бусад этгээдтэй зөвлөлдөх, хууль ёсны асран хамгаалагч томилуулах зэрэг шаардлагатай хамгаалалтын арга хэмжээ авна.

3.Хуульч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээ авахдаа зөвхөн үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай хэмжээнд үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийг задруулж болно.

2.13 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн эд хөрөнгийг хадгалах

1.Хуульч нь үйлчилгээ үзүүлэх явцад зайлшгүй шаардлагаар үйлчлүүлэгчийн эсхүл гуравдагч этгээдийн эд хөрөнгийг хүлээн авч болох боловч тухайн эд хөрөнгийг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулж, ашиглаж болохгүй. Энэ тохиолдолд мөнгөн хөрөнгийг хуульчийн данснаас тусдаа дансанд, бусад эд хөрөнгийг онцлогт нь тохируулан зохих ёсоор хадгална. Хадгалсан эд хөрөнгийн талаар тэмдэглэл хөтөлж, үүнтэй холбоотой баримт бичгийг үйлчилгээ дууссанаас хойш таван жилээс доошгүй хугацаанд хадгална.

2.Хууль зүйн үйлчилгээтэй холбоотой урьдчилан төлөгдсөн зардлыг хуульч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дансанд байршуулна.

3.Хуульч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг хүлээн авсан талаар үйлчлүүлэгч эсхүл холбогдох гуравдагч этгээдэд даруй мэдэгдэнэ.

4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хуульч нь үйлчлүүлэгч эсхүл гуравдагч этгээдийн хөрөнгийг үйлчлүүлэгч эсхүл гуравдагч этгээдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлж дууссанаас хойш ажлын 10 хоногт багтаан хүлээлгэн өгнө. Үйлчлүүлэгч эсхүл гуравдагч этгээд хүсвэл хөрөнгийн данстай холбоотой болон бусад баримт бичгийн хуулбарыг даруй гаргаж өгнө.

5.Хуульч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийн өмчлөлийн талаар маргаж байгаа бол маргаан шийдвэрлэгдэх хүртэл тухайн хөрөнгийг хадгална. Тухайн хөрөнгийн өмчлөх эрхийн маргаангүй хэсгийг даруй хуваарилж өгнө.

2.14 дүгээр зүйл.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах

1.Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хуульч хэрэг, маргааныг бүрэн шийдвэрлэж дуусахаас өмнө үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

2.Хуульч нь дараах нөхцөлд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй:

2.1.үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлснээр хууль эсхүл энэ дүрмийг зөрчихөөр бол;

2.2.хуульчийн биеийн эрүүл мэнд, эсхүл сэтгэцийн байдал тухайн үйлчилгээг үзүүлэхэд саад учруулахаар байвал;

2.3.хуульч урьд нь тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч, прокурор, хууль сахиулагч, иргэдийн төлөөлөгч, гэрч, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын хувиар оролцож байсан;

2.4.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шүүгч, прокурор эсхүл эсрэг талын хуульч нь тухайн хуульчтай хамаарал бүхий этгээд гэдгийг үйлчилгээ үзүүлж эхлэхээс өмнө мэдсэн бол;

2.5.өмгөөлөгч өөрөө тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр зайлшгүй оролцох магадлалтай бол;

2.6.үйлчлүүлэгч нь хууль зүйн үйлчилгээг гэмт хэрэг үйлдэхэд ашигласан;

2.7.үйлчлүүлэгч үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой гэрээг цуцалсан, эсхүл гэрээнээс татгалзсан.

3.Хуульч нь дараах нөхцөлд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно:

3.1.уг татгалзал нь үйлчлүүлэгчийн эрх ашигт ноцтой хохирол учруулахгүй;

3.2.хуульчийн мэргэжлийн зөвлөгөөг үл харгалзан үйлчлүүлэгч нь хууль зүйн үйлчилгээг ашиглан хууль бус үйл ажиллагаа явуулахаар байвал;

3.3.хуульчийн зүгээс хүлээн зөвшөөрөх боломжгүй үйл ажиллагаанд хууль зүйн үйлчилгээ авахыг үйлчлүүлэгч нь хүссэн бол;

3.4.үйлчлүүлэгч нь үйлчилгээтэй холбоотой хуульчийн өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор удаа дараа биелүүлэхгүй бол;

3.5.зайлшгүй татгалзах бусад үндэслэл байгаа.

2.15 дугаар зүйл.Хууль зүйн үйлчилгээг дуусгавар болгох

1.Хуульч шүүгч, прокурор, эсхүл хууль зүйн үйлчилгээ үзүүлэхэд саад болох бусад албан тушаалд томилогдсон, нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон зэрэг гарцаагүй нөхцөлийн улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн үйлчилгээг хугацаанаас өмнө дуусгавар болгоно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үйлчилгээг дуусгавар болгосон тохиолдолд тухайн хуульч эсхүл түүний эрх залгамжлагч нь үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд тухайн үйлчилгээг өөр хуульч, өмгөөллийн нөхөрлөлд шилжүүлэх тухай саналыг үйлчлүүлэгчид тавьж болно.

3.Хуульч үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан эсхүл дуусгавар болгосон бол тухайн шийдвэрийн үндэслэлийг тайлбарласан мэдэгдэл, үйлчлүүлэгчийн баримт бичиг, эд хөрөнгө, түүнд буцаан төлвөл зохих хөлс, зардлын үлдэгдлийг хүлээлгэн өгөх зэрэг шаардлагатай арга хэмжээг авна.

2.16 дугаар зүйл.Боломжит үйлчлүүлэгчтэй харилцах

1.Хууль зүйн үйлчилгээ авах тухай хүсэл зоригоо хуульчид илэрхийлсэн этгээдийг боломжит үйлчлүүлэгч гэнэ.

2.Хуульч болон үйлчлүүлэгчийн харилцаа үүсээгүй ч хуульч нь боломжит үйлчлүүлэгчээс хүлээн авсан мэдээллийг түүний ашиг сонирхлын эсрэг ашиглах, эсхүл энэ дүрмийн 2.5 дугаар зүйлд зөвшөөрснөөс бусад тохиолдолд задруулахыг хориглоно.

3.Боломжит үйлчлүүлэгчээс хүлээн авсан мэдээлэл нь түүний ашиг сонирхлыг ноцтой хохироох бол хуульч боломжит үйлчлүүлэгчийн эсрэг ашиг сонирхол бүхий этгээдэд тухайн асуудлаар хууль зүйн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Хэрэв хуульч нь энэ зүйлд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхгүй тохиолдолд түүнтэй нэг өмгөөллийн нөхөрлөлд ажиллаж байгаа бусад хуульч нь мөн адил тухайн этгээдэд үйлчилгээ үзүүлэх, эсхүл үргэлжлүүлэхийг хориглоно.

4.Хуульч нь боломжит үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эсэхээ нэн даруй мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

3.1 дүгээр зүйл.Хууль зүйн зөвлөгөө

1.Хуульч нь хараат бус байж, үнэн, бүрэн, ойлгомжтой байдлаар зөвлөгөөг өгнө.

2.Хуульч нь хууль зүйн зөвлөгөө өгөхдөө үйлчлүүлэгчийн нөхцөл байдалтай холбогдож болох хууль тогтоомж төдийгүй ёс суртахуун, улс төр, нийгэм, эдийн засгийн зэрэг бусад хүчин зүйлийн талаар дурдаж болно.

3.2 дугаар зүйл.Гуравдагч этгээдэд зориулсан хууль зүйн дүгнэлт

1.Хуульч нь үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд сөргөөр нөлөөлөхгүй гэдэгт үндэслэлтэйгээр итгэж байгаа бөгөөд үйлчлүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд үйлчлүүлэгчтэй холбоотой асуудлаар гуравдагч этгээдэд хууль зүйн дүгнэлт өгч болно.

2.Үйлчлүүлэгчээс мэдээлэлтэй зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хуульч нь хууль зүйн дүгнэлт өгснөөр үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг бодитойгоор хохироох боломжтой гэдгийг мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан бол гуравдагч этгээдэд дүгнэлт өгөхийг хориглоно.

3.Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол хууль зүйн дүгнэлттэй холбоотой мэдээлэл нь энэ дүрмийн 2.5 дугаар зүйлд зааснаар хамгаалагдана.

3.3 дугаар зүйл.Хөндлөнгийн этгээдийн хувьд үзүүлэх үйлчилгээ

1.Хуульч нь хоёр эсхүл түүнээс дээш этгээдийн хооронд үүссэн асуудлыг шийдвэрлэхэд хөндлөнгийн этгээдийн хувьд үйлчилгээ үзүүлж болно. Хөндлөнгийн этгээдийн хувьд үзүүлэх үйлчилгээ гэж арбитрын, эвлэрүүлэн зуучлалын эсхүл талуудын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн адилтгах бусад ажиллагааг ойлгоно.

2.Хөндлөнгийн этгээдийн хувьд үйлчилгээ үзүүлж байгаа хуульч нь аль ч талтай хуульч болон үйлчлүүлэгчийн харилцаагүй байх бөгөөд энэ тухайгаа талуудад мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

4.1 дүгээр зүйл.Үндэслэл бүхий шаардлага, тайлбар гаргах

1.Өмгөөлөгч хууль зүйн болон үйл баримтын талаар үндэслэл бүхий шаардлага, тайлбар гаргана.

2.Яллагдагчийн өмгөөлөгч нь өөрийн үйлчлүүлэгчийн гэм бурууг бүрэн нотлохыг прокуророос шаардах эрхтэй бөгөөд хууль болон нотлох баримтын талаарх түүний эргэлзээг ялимгүй эсхүл ач холбогдолгүй гэж үзэхгүй.

4.2 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах

1.Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхолд нийцүүлэн хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах талаар чармайн ажиллана.

2.Өмгөөлөгч нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, эсрэг тал эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, өөртөө эсхүл үйлчлүүлэгчдээ санхүүгийн ашигтай байдал бий болгох, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно.

4.3 дугаар зүйл.Үнэнийг мэдүүлэх

1.Өмгөөлөгчид дараах санаатай үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

1.1.Үндсэн хуулийн цэц, шүүх, арбитр эсхүл хэрэг, маргаан хянан шийдвэрлэх бусад байгууллагад үйл баримтын талаар худал мэдээлэл өгөх;

1.2.нотлох баримтын агуулгыг гуйвуулан тайлбарлах, хуурамч нотлох баримтыг зориуд гаргаж өгөх;

1.3.урьд нь өгсөн үйл баримтын талаарх мэдээлэл эсхүл нотлох баримт нь худал гэдгийг мэдсэн боловч энэ тухай энэ зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан байгууллагад мэдэгдэх зэргээр зөвтгөх арга хэмжээ авахгүй байх.

2.Өмгөөлөгч нь үйлчлүүлэгч эсхүл бусад этгээд хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж байгаа, үйлдэж байгаа, эсхүл үйлдсэн тухай баттай мэдсэн бол тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг зогсоох талаар зөвлөх, зохих байгууллагад мэдэгдэх зэрэг шаардлагатай арга хэмжээ авна.

3.Өмгөөлөгч нь энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан үүргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусах хүртэл биелүүлэх бөгөөд энэ үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд энэ дүрмийн 2.5 дугаар зүйлээр хориглосон эсэхээс үл хамааран мэдээллийг задруулна.

4.4 дүгээр зүйл.Эсрэг тал болон түүний хуульчид шударга хандах

1.Өмгөөлөгчид дараах үйлдэл, эс үйлдэхгүйг хориглоно:

1.1.эсрэг тал нотлох баримт олж авахад саад учруулах, эсхүл нотолгооны ач холбогдолтой байж болох баримт бичиг, бусад материалыг хууль бусаар өөрчлөх, устгах, нуун дарагдуулах, эсхүл ийм үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвлөх, туслах;

1.2.нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх, худал мэдүүлэг өгөхийг гэрчид зөвлөх, туслах, эсхүл гэрчид хууль бусаар нөлөөлөх;

1.3.хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ач холбогдолгүй нотлох баримт гаргуулах хүсэлт гаргах, эсхүл нотлох баримт гаргуулах тухай эсрэг талын хууль ёсны хүсэлтийг биелүүлэхгүй байх;

1.4.хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг эсрэг талд сайн дураар өгөхөөс татгалзахыг өөрийн үйлчлүүлэгчээс бусад этгээдэд зөвлөх.

2. Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэй хамаарал бүхий этгээд, түүний ажилтан эсхүл түүнийг төлөөлөх бусад эрх бүхий этгээдийн ашиг сонирхолд ноцтой хохирол учрахгүй гэж үндэслэлтэйгээр итгэж байгаа бол энэ зүйлийн 1.4 дэхь хэсэгт заасан зөвлөгөөг энэ хэсэгт заасан этгээдэд өгч болно.

4.5 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг сахих

1.Өмгөөлөгч хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлнэ.

2.Өмгөөлөгчид дараах үйлдэл, эс үйлдэхгүйг хориглоно:

2.1.үндэслэл бүхий татгалзал гаргаснаас бусад тохиолдолд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх байгууллагын өмнө хүлээсэн үүргээ санаатайгаар үл биелүүлэх;

2.2.шүүгч, арбитрч, эвлэрүүлэн зуучлагч, бусад хөндлөнгийн этгээд, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид хуулиар хориглосон аргаар нөлөөлөх эсхүл нөлөөлөхийг оролдох;

2.3.хуульд эсхүл энэ дүрэмд зөвшөөрснөөс бусад тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, арбитрч, эвлэрүүлэн зуучлагч, бусад хөндлөнгийн этгээдтэй хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр харилцах;

2.4.энэ зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан этгээдтэй үүссэн хувийн харилцаагаа давуу байдал болгох замаар хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх;

2.5.шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцсон иргэнтэй түүний оролцсон хэрэг, маргаантай нь холбогдуулан харилцах;

2.6.хэрэг, маргаанд ач холбогдолгүй эсхүл нотлох баримтгүй зүйлээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах;

2.7.өөрөө гэрчийн мэдүүлэг өгч байгаагаас бусад тохиолдолд үйл баримтын тухай хувийн байр сууриа илэрхийлэх, эсхүл асуудлын үндэслэл нь үнэн зөв эсэх, гэрч нь итгэл даахуйц эсэх, хариуцагчийн зөв буруу эсэх, яллагдагчийн гэм буруутай эсэх талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх;

2.8.хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зорилготой үйл ажиллагаанд оролцох.

4.6 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх

1.Өмгөөлөгч нь шаардлагатай гэж үзвэл дараах мэдээллийг энэ дүрмийн 1.11 дүгээр зүйлийг зөрчихгүйгээр хийж болно:

1.1.нэхэмжлэлийн шаардлага, зөрчил, гэмт хэрэг, эсхүл хуулиар хориглоогүй бол холбогдох этгээдийн талаар;

1.2.олон нийтэд нэгэнт ил болсон;

1.3.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны талаар;

1.4.шаардлагатай нотлох баримт болон мэдээлэл цуглуулахад туслалцаа хүсэх;

1.5.хувь хүн эсхүл олон нийтэд ноцтой хохирол учруулах үндэслэл байгаа тохиолдолд холбогдох этгээдийн зан байдал аюул учруулж болохуйц гэдгийг анхааруулах.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан хуульч олон нийтэд ил болсон мэдээллийн сөрөг нөлөөнөөс үйлчлүүлэгчээ хамгаалах зорилгоор шаардлагатай, үндэслэл бүхий мэдээлэл хийж болно.

3.Өмгөөлөгчийн мэдээлэл хийхтэй холбоотой эрх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хориглогдож байгаа бол энэ хориглолт нь тухайн хуульчтай нэг өмгөөллийн нөхөрлөлд хамт ажилладаг бусад хуульчид мөн адил хамаарна.

4.7 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад ажиллагаанд оролцох

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадуур хууль тогтоох байгууллага эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын өмнө үйлчлүүлэгчээ төлөөлж оролцохдоо хуульч нь төлөөллийнхөө талаар мэдэгдэх бөгөөд энэ дүрмийн 4.3 дугаар зүйл, 4.4 дүгээр зүйлийн 1.1-1.3 дахь хэсэг, болон 4.5 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БУС ЭТГЭЭДТЭЙ ХАРИЛЦАХ

5.1 дүгээр зүйл.Гуравдагч этгээдэд мэдээлэл өгөх

1.Хуульч нь гуравдагч этгээдэд хууль болон үйл баримтын талаар худал мэдээлэл өгөхийг хориглоно.

2.Үйлчлүүлэгч гэмт хэрэг үйлдэхдээ гуравдагч этгээдийг ашиглаж байгааг хуульч мэдсэн бол энэ дүрмийн 2.5 дугаар зүйлд хориглосноос бусад тохиолдолд гэмт хэрэг үйлдэхээс зайлсхийхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг гуравдагч этгээдэд гаргаж өгнө.

5.2 дугаар зүйл.Бусад хуульчаас үйлчилгээ авч буй этгээдтэй харилцах

1.Хуульч нь өөрийн үйлчлүүлэгчийн эсрэг этгээдтэй түүний хуульчийг байлцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой асуудлаар харилцахыг хориглоно. Тухайн этгээдийн хуульч нь зөвшөөрсөн эсхүл хуульд заасан тохиолдолд энэ хориглолт нь хамаарахгүй.

5.3 дугаар зүйл.Хуульчаас үйлчилгээ аваагүй этгээдтэй харилцах

1.Хуульч үйлчлүүлэгчийнхээ өмнөөс хуульчаас үйлчилгээ аваагүй этгээдтэй харилцахдаа үйлчлүүлэгчдээ үйлчилгээ үзүүлээгүй гэж түүнд мэдэгдэх, эсхүл тийм ойлголт төрүүлэхийг хориглоно.

2.Хуульчаас үйлчилгээ аваагүй этгээд нь тухайн хуульчийн хамгаалж буй ашиг сонирхол, үүргийг буруугаар ойлгож байгааг мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан бол хуульч нь буруу ойлголтыг засахад шаардлагатай арга хэмжээ авна.

3.Хуульч нь хуульчаас үйлчилгээ аваагүй этгээдийн ашиг сонирхол өөрийн үйлчлүүлэгчийн ашиг сонирхолтой зөрчилдөхүйц гэдгийг мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан бол тухайн этгээдэд хуульчаас үйлчилгээ авах хэрэгтэй гэдгээс бусад зөвлөгөө өгч болохгүй.

5.4 дүгээр зүйл.Гуравдагч этгээдийн эрхийг хүндлэх

1.Хуульч нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, эсхүл тухайн этгээдийн эрхийг зөрчиж нотлох баримт бүрдүүлэхийг хориглоно.

2.Хуульч нь бусад этгээдээс үйлчлүүлэгчтэйгээ холбоотой баримт бичиг, эсхүл цахим мэдээлэл хүлээн авсан боловч тухайн баримт бичиг, мэдээллийг андуурч явуулсан гэдгийг мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан тохиолдолд илгээсэн этгээдэд нь энэ тухай даруй мэдэгдэнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ӨМГӨӨЛЛИЙН НӨХӨРЛӨЛ

6.1 дүгээр зүйл.Өмгөөллийн нөхөрлөлийн гишүүн, удирдах албан тушаал эрхэлж байгаа хуульч, эсхүл бусад хуульчийг удирдаж байгаа хуульч

1.Өмгөөллийн нөхөрлөлийн гишүүн (цаашид "нөхөрлөлийн гишүүн" гэх) болон удирдах албан тушаал эрхэлж байгаа хуульч нь тухайн нөхөрлөлд ажиллаж байгаа хуульчид энэхүү дүрмийг мөрдөж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээ авна.

2.Хуульч нь өөрийн удирдлага дор ажиллаж байгаа хуульч энэхүү дүрмийг мөрдөж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээ авна.

3.Хуульч нь бусад хуульчид энэхүү дүрмийг зөрчсөн үйл ажиллагааг явуулах даалгавар өгсөн, эсхүл зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдсээр байж зөвшөөрсөн бол тухайн хуульчийн гаргасан зөрчилд зохих хариуцлага хүлээнэ.

4.Зөрчил гаргасан хуульчийн ажилладаг нөхөрлөлийн гишүүн, удирдах албан тушаал эрхэлж байгаа хуульч, эсхүл тухайн хуульчийг удирдан ажиллаж байгаа хуульч нь энэ дүрмийг зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдсээр байж түүний үр дагавраас урьдчилан сэргийлэх эсхүл бууруулах боломжийг ашиглаагүй, шаардлагатай залруулах арга хэмжээ аваагүй бол тухайн зөрчилд зохих хариуцлага хүлээнэ.

6.2 дугаар зүйл.Бусад хуульчийн удирдлагад ажиллаж буй хуульч

1.Хуульч нь бусад хуульчийн удирдлага, өгсөн чиглэлийн дагуу ажиллаж байгаа эсэхээс үл хамааран энэхүү дүрмийг биелүүлнэ.

6.3 дугаар зүйл.Хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн өмнөөс хүлээх хуульчийн хариуцлага

1.Нөхөрлөлийн гишүүн эсхүл удирдах албан тушаал эрхэлж байгаа хуульч нь тухайн нөхөрлөлд ажиллаж байгаа хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн үйл ажиллагаа энэ дүрэмд нийцсэн байх талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

2.Хуульч өөрийн удирдлагад ажиллаж байгаа хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн үйл ажиллагаа энэ дүрэмд нийцсэн байх талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

3.Хуульч энэ дүрмийг зөрчсөн үйл ажиллагааг явуулах даалгавар өгсөн, эсхүл тухайн үйл ажиллагааны талаар мэдсээр байж зөвшөөрсөн бол хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн тухайн үйл ажиллагаанд зохих хариуцлага хүлээнэ.

4.Зөрчил гаргасан хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн ажилладаг нөхөрлөлийн гишүүн, удирдах албан тушаал эрхэлж байгаа хуульч, эсхүл тухайн этгээдийг удирдан ажиллаж байгаа хуульч нь энэ дүрмийг зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдсээр байж түүний үр дагавраас урьдчилан сэргийлэх эсхүл багасгах боломжтой байхад залруулах шаардлагатай арга хэмжээ аваагүй тохиолдолд тухайн зөрчилд зохих хариуцлага хүлээнэ.

5.Хуульч нь хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн санаатай үйл ажиллагааны улмаас энэ дүрэм зөрчигдсөнөөс бусад тохиолдолд тухайн зөрчилд энэ дүрмээр зохих хариуцлага хүлээнэ.

6.4 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн хараат бус байдал

1.Хуульч нь хуульчийн зөвшөөрөлгүй этгээдтэй хууль зүйн үйлчилгээний хөлс хуваахыг хориглоно.

2.Хуульч нь хуульчийн зөвшөөрөлгүй этгээдтэй хамтран хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг нөхөрлөл байгуулахыг хориглоно.

3.Үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхийг зөвлөсөн, тийм зорилгоор ажилд авсан, эсхүл хөлсийг нь төлсөн гуравдагч этгээдийн зүгээс мэргэжлийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийг хуульч зөвшөөрч болохгүй.

6.5 дугаар зүйл.Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эрхийг хязгаарласан гэрээ

1.Хуульч нь тэтгэвэрт гарсны дараа авах тэтгэмжтэй холбоотойгоос бусад тохиолдолд гэрээ дуусгавар болсноор хууль зүйн үйлчилгээ үзүүлэх эрхээ хязгаарлуулах агуулгатай заалт тухайн гэрээнд оруулах санал гаргах эсхүл бусдын ийм саналыг хүлээн авахыг хориглоно.

6.6 дугаар зүйл.Хууль зүйн үйлчилгээтэй холбогдож болох үйлчилгээ

1.Хууль зүйн үйлчилгээтэй холбогдож болох үйлчилгээ гэдэгт хууль зүйн үйлчилгээтэй нягт холбоотой бөгөөд хуульчийн зөвшөөрөлгүй этгээд эрхлэн явуулахыг хориглоогүй үйлчилгээг ойлгоно.

2.Дараах тохиолдолд хуульч нь хууль зүйн үйлчилгээтэй холбогдож болох үйлчилгээ үзүүлэхдээ энэхүү дүрэмд захирагдана:

2.1.хуульчийн хууль зүйн үйлчилгээг түүний үзүүлж байгаа хууль зүйн үйлчилгээтэй холбогдож болох үйлчилгээнээс ялгах боломжгүй;

2.2.хууль зүйн үйлчилгээтэй холбогдож болох үйлчилгээ нь хууль зүйн үйлчилгээ биш бөгөөд хуульч болон үйлчлүүлэгч хоорондын харилцаа үүсээгүй гэдгийг тухайн үйлчилгээ авч байгаа этгээдэд ойлгомжтой тайлбарлаагүй.

6.7 дугаар зүйл.Өмгөөллийн нөхөрлөлд ажиллаж буй хуульчдын үүрэг, хариуцлага бусад хуульчдад хамаарах нь

1.Өмгөөллийн нөхөрлөлөөс бусад аливаа хуулийн этгээдийн хууль зүйн асуудал хариуцсан нэгжид эсхүл хоорондоо гэрээгээр хамтран ажиллаж байгаа хуульч нь энэ дүрмээр өмгөөллийн нөхөрлөлд ажиллаж буй хуульчид хүлээлгэсэн үүрэг, хариуцлагыг биелүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1 дүгээр зүйл. Нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг сайн дураар явуулах

1. Хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг сайн дураар хөлс авахгүйгээр эсхүл бага хөлсөөр явуулахыг эрмэлзэх бөгөөд дараах хэлбэрээр гүйцэтгэж болно:

1.1. төлбөрийн чадваргүй эсхүл бага орлоготой хүнд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;

1.2. төлбөрийн чадваргүй эсхүл бага орлоготой хүнд туслах зорилготой байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;

1.3. иргэний болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгаажуулах зорилготой хувь хүн, бүлэг, байгууллагад хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;

1.4. хууль зүйн үйлчилгээний хөлс төлөхөд санхүүгийн эх үүсвэрийнхээ дийлэнх хэсгийг зарцуулах байдалд байгаа төрийн, төрийн бус, боловсролын, иргэний, эсхүл сайн үйлийн байгууллагад зорилгоо биелүүлэхэд нь зориулж хууль зүйн үйлчилгээ үзүүлэх;

2. Хуульч нь төлбөрийн чадваргүй эсхүл орлого багатай иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, хууль зүйн боловсрол, шинжлэх ухаан, хуулийн шинэтгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

3. Хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг явуулснаар энэ дүрмийн 2.6 дугаар зүйлийн дагуу үйлчлүүлэгчийнхээ өмнө хүлээсэн үүргээ зөрчиж болзошгүй тохиолдолд тухайн үйл ажиллагааг явуулахаас татгалзана.

7.2 дугаар зүйл. Эрх зүйн шинэтгэлд оролцох

1. Хуульч эрх зүйн шинэтгэлтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох явцад өөрийн үйлчлүүлэгчид нь ашигтай байдал бий болох боломж бүрдсэн тохиолдолд энэ талаар тухайн үйл ажиллагаанд оролцогч бусад этгээдэд мэдэгдэх бөгөөд үйлчлүүлэгчийнхээ хувийн мэдээллийг задруулах шаардлагагүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ СУРТАЛЧИЛГАА

8.1 дүгээр зүйл. Сурталчилгаа

1. Энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсгийг зөрчөөгүй тохиолдолд хуульч нь өөрийн үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой сурталчилгааг хуульд заасан журмын дагуу явуулж болно.

2. Хуульч нь өөрийнхөө болон хууль зүйн үйлчилгээнийхээ талаар худал эсхүл төөрөгдүүлсэн агуулгатай сурталчилгаа явуулахыг хориглоно.

3. Хууль зүйн үйлчилгээний тухай сурталчилгаанд түүнд хариуцлага хүлээх хуульч эсхүл өмгөөллийн нөхөрлөлийн нэр, хаягийг заавал дурдана.

8.2 дугаар зүйл. Ятгахыг хориглох

1. Хуульч нь зөвхөн ашиг олох зорилгоор эсхүл хүч хэрэглэх, дарамт үзүүлэх, айлган сүрдүүлэх, гарцаагүй байдалд оруулах зэрэг зүй бус аргаар хууль зүйн үйлчилгээнийхээ талаар тухайлсан этгээдтэй уулзах, утсаар ярих, бичгэн, дуу эсхүл дүрс бичлэг, цахим зэрэг хэлбэрээр харилцаж ятгахыг хориглоно.

ГУРАВДУГААР АНГИ ПРОКУРОР

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.

ПРОКУРОРЫН ХАРААТ БУС, ЗАРЧИМЧ БАЙДАЛ

9.1 дүгээр зүйл.Бодит үнэнийг эрэлхийлэх, шударга ёсыг тогтоолгох

1.Прокурор нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодит үнэнийг эрэлхийлж, шүүхээр шударга ёсыг тогтоолгохын төлөө хараат бусаар ажиллана.

2.Прокурор нь албан үүргээ гүйцэтгэхдээ хууль тогтоомжийг чанд сахиулж, олон улсын гэрээ болон хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангаж ажиллана.

3.Прокурор нь шүүхийн өмнө яллагдагчийн гэм бурууг нотлох үүрэгтэй бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага зайлшгүй байх, хуулийг нэг мөр хэрэглэх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг мөрдөж ажиллана.

9.2 дугаар зүйл.Прокурорын нийтлэг үүрэг

1.Прокурор нь хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо дараах нийтлэг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.прокурорын шийдвэр нь улс төр, хэвлэл мэдээлэл, олон нийтийн зэрэг аливаа дарамт, шахалт, ашиг сонирхлоос ангид байж зөвхөн хууль болон нотлох баримтад үндэслэсэн, ойлгомжтой байх;

1.2.хүсэлт, гомдол, мэдээллийг хуульд заасан хугацааны дотор шуурхай шийдвэрлэх, хууль зүйн үндэслэлтэй хариу өгөх;

1.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах;

1.4.хувийн ашиг сонирхлын үүднээс өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарахгүй хэрэг, материалтай танилцах, хэрхэн шийдвэрлэх талаар хүсэлт тавих, заавар, зөвлөгөө өгөхгүй байх;

1.5.нийгэмд буй болсон дургүйцэл, ялгаварлалыг давуу тал болгон ашиглах зэрэг зүй бус арга хэрэглэхгүй байх.

9.3 дугаар зүйл.Прокурорын нэр хүндийг урвуулан ашиглахгүй байх

1.Прокурор хувийн ашиг сонирхлоо хангах зорилгоор прокурорын албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, эсхүл бусад этгээдэд тийнхүү ашиглахыг зөвшөөрч болохгүй.

9.4 дүгээр зүйл.Тэгш хандах

1.Прокурор албан үүргээ гүйцэтгэхдээ нас, хүйс, арьсны өнгө, жендэр, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн байдал, нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, хөрөнгө чинээ, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн байр суурь зэргээр ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэхийг хориглоно.

2.Прокурор нь туслах ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт хориглосон үйлдэл, эс үйлдэхүй гаргасныг мэдсэн бол зогсоох арга хэмжээ авна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл нь хэргийн шинжид хамаарах тохиолдолд прокуророос тухайн нөхцөлийг зүй ёсоор дурдсаныг энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөнд тооцохгүй.

9.5 дугаар зүйл.Прокурорын үйл ажиллагааг гадны нөлөөллөөс хамгаалах

1.Прокурор улс төр, нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдал эсхүл олон нийтийн дургүйцэл, шүүмжлэлд автаж шийдвэр гаргаж болохгүй.

2.Прокурор үйл ажиллагаа явуулахдаа гэр бүл, нийгэм, улс төр, санхүүгийн зэрэг ашиг сонирхлын аливаа нөлөөлөлд автаж болохгүй.

3.Прокурор аливаа этгээд өөрт нь нөлөөлөх байр суурьтай гэсэн ойлголт төрүүлж болохгүй бөгөөд бусад этгээдийн зүгээс тийм ойлголт төрүүлсэн талаар мэдсэн бол залруулах арга хэмжээ авна.

9.6 дугаар зүйл.Дээд шатны прокурорын үндэслэлгүй шийдвэрийг биелүүлэхээс татгалзах

1.Дээд шатны прокурорын шийдвэр нь яллагдагч, ялтан болон хэргийн бусад оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчинө гэж үндэслэлтэйгээр итгэж байгаа бол прокурор нь тухайн шийдвэрийг биелүүлэхээс татгалзана.

2.Дээд шатны прокурорын шийдвэр нь хууль бус гэдгийг мэдсээр байж шийдвэрийг биелүүлсэн бол тухайн прокурор болон шийдвэр гаргасан дээд шатны прокурор энэ дүрмийн дагуу зохих хариуцлага хүлээнэ.

9.7 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх

1.Прокурор нь яллагдагчийн эрхийг хүндэтгэхийн зэрэгцээ олон нийтэд учрах аюул болон гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл авах иргэдийн хэрэгцээг хангахын төлөө чармайн ажиллана.

2.Хууль эсхүл энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол прокурор нь хууль сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нийтэд ил болсон мэдээллийн сөрөг нөлөөнөөс мөрдөн шалгах ажиллагааг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, шударга ёсны тогтолцоонд итгэх иргэдийн итгэлийг хадгалах, нийгэмд үүссэн айдас, бухимдлыг намжаах, төөрөгдлийг арилгах зорилгоор шаардлагатай тохиолдолд дараах мэдээллийг өгч болно:

- 2.1.гэмт хэрэг гарсан талаар;
- 2.2.шаардлагатай нотлох баримт болон мэдээлэл цуглуулахад туслалцаа хүсэх;
- 2.3.хувь хүн эсхүл олон нийтэд ноцтой хохирол учруулах үндэслэл байгаа тохиолдолд холбогдох этгээдийн зан байдал аюул учруулж болохуйц гэдгийг анхааруулах;
- 2.4.яллахад шаардлагатай нотлох баримт байгаа эсэх;
- 2.5.яллагдагчийг баривчилсан эсэх;
- 2.6.баривчилгаа явуулсан цаг, газар, баривчилгаа явуулсан байгууллага, баривчилгааны явцад хураан авсан эд зүйл;
- 2.7.яллагдагчийн нэр, нас;
- 2.8.мөрдөн шалгаж байгаа байгууллага, мөрдөн шалгах хугацаа, хүрээ, журам;
- 2.9.нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай олон нийтэд ил болсон мэдээлэл.

9.8 дугаар зүйл.Олон нийтэд өгөх мэдээллийн хязгаарлалт

1.Прокуророос олон нийтэд өгөх аливаа мэдээлэл нь эцэслэн шийдвэрлэгдээгүй хэргийн талаар урьдчилсан дүгнэлт хийсэн, хувийн байр сууриа илэрхийлсэн, хэргийн оролцогчийн хувийн мэдээллийг агуулсан, яллагдагч руу чиглэсэн олон нийтийн буруутгалыг дэвэргэсэн шинж, агуулгатай байж болохгүй.

2.Олон нийтэд ил болсноос бусад тохиолдолд прокурор нь дараах мэдээллийг олон нийтэд хийхийг хориглоно:

- 2.1.гэмт хэрэг үйлдсэн арга, хэрэгслийг нарийвчлан заасан мэдээлэл;
- 2.2. төр, байгууллага, хувь хүний нууцтай холбогдох мэдээлэл;
- 2.3.тухайн хэргийн гүйцэтгэх ажилтай холбогдох баримт;
- 2.4.хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь хэрэг илрүүлэх, нотлох баримт цуглуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагаатай холбогдох мэдээлэл;

2.5.тухайн хэрэгт цугларсан шалгагдаж нотлогдоогүй баримт, эргэлзээтэй нотлох баримтын талаар;

2.6.шүүхээр тогтоогдоогүй байхад яллагдагчийн гэм буруу нотлогдсон мэт мэдэгдэх, эсхүл тийм ойлголт төрүүлэхүйц;

2.7.гэрчийн мэдүүлэг өгч болох этгээдийн тухай;

2.8.яллагдагч эсхүл гэрчийн мэдүүлэг өгч болох этгээдийн хувийн зан байдал, нэр хүнд, урьд нь үйлдэж байсан гэмт хэргийн талаар;

2.9.хохирогч, гэрч болон бусад оролцогчдын овог, нэр, хаяг;

2.10.яллагдагчийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн болон бусад мэдээллийн агуулга;

2.11.шүүхийн шинжээчийн дүгнэлт, эсхүл яллагдагчийн шинжилгээ өгөхөөс татгалзсан эсэх.

3.Прокурор нь шүүхийн шийдвэрийн үндэслэлийн талаар өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлж болох бөгөөд энэ мэдээлэл нь шүүгчийн ёс зүй, зарчимч байдал, мэдлэг, ур чадварыг дүгнэсэн шинж агуулж болохгүй.

4.Прокурор гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд өгөх үүргийг ойлгож хэрэгжүүлэхэд нь хууль сахиулагчид туслаж ажиллана.

5.Прокурор нь энэ дүрмээр хориглосон мэдээллийг хууль сахиулагч, эсхүл өөрийн удирдлага дахь ажилтан задруулахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээ авна.

АРАВДУГААР БҮЛЭГ ПРОКУРОРЫН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

10.1 дүгээр зүйл.Ашиг сонирхлын зөрчил

1.Прокурор нь өөрийн албан үүрэгтэй зөрчилдөх, эсхүл зөрчигдсөн гэж ойлгогдохуйц санхүүгийн болон бусад ашиг сонирхолтой байх, эсхүл тийм үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

2.Прокурор албан үүргээ бодитой, шударгаар хэрэгжүүлэхэд харшлах, эсхүл сөргөөр нөлөөлөх аливаа хэлцэл, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, бизнесийн бусад ашиг сонирхлоос татгалзана.

10.2 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах

1.Прокурор нь дараах тохиолдолд гэмт хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

1.1.урьд нь үзүүлж байсан хууль зүйн үйлчилгээтэй холбоотой хэрэгт эсхүл урьд нь үйлчлүүлэгч байсан этгээд яллагдагч байвал;

1.2.урьд нь хууль зүйн үйлчилгээ үзүүлж байхдаа олж авсан мэдээлэл нь тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал ач холбогдолтой байвал;

1.3.прокурортой хамаарал бүхий этгээд нь яллагдагч, түүний өмгөөлөгч, эсхүл хохирогч байвал;

1.4.прокурор өөрөө тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр зайлшгүй оролцох магадлалтай;

1.5.хуулиар хүлээсэн албан үүргээ бодитой, шударгаар гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал.

2.Прокурор нь ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй тохиолдолд энэ талаар дээд шатны прокурорт даруй мэдэгдэнэ.

3.Прокурор нь яллах үндэслэл байхгүй гэдгийг мэдсээр байж илтэд гэмт хэргийн шинжгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эсхүл яллах ажиллагаа явуулахыг хориглоно.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
ПРОКУРОРЫН АЛБАН ҮҮРГЭЭС БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХУВИЙН АМЬДРАЛ**

11.1 дүгээр зүйл.Прокурорын албан үүргээс бусад үйл ажиллагаа

1.Прокурор хууль эсхүл энэ дүрэмд хориглосноос бусад тохиолдолд прокурорын албан үүргээс бусад үйл ажиллагаанд оролцож болно.

2.Прокурор өөрийн албан үүргээс бусад дараах үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

- 2.1.албан үүргээ зохистой хэрэгжүүлэхэд саад болохуйц;
- 2.2.энэ зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын улмаас хэргийн оролцогчийн зүгээс прокуророос татгалзахад хүргэх;
- 2.3.прокурорын хараат бус, зарчимч байдлыг алдагдуулах;
- 2.4.хүч хэрэглэсэн мэт ойлгогдох.

3.Прокурор туслах ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг, даалгавар өгч болохгүй.

4.Прокурор нь хуулиар зөвшөөрсөн, эсхүл прокурорын албан үүрэг, хууль зүйн хөгжил, боловсрол зэрэг хууль зүйн асуудалтай холбоотойгоос бусад зорилгоор прокурорын байгууллагын байр, техник, санхүү, мэдээллийн хэрэгсэл, бичиг хэрэг зэрэг эх үүсвэрийг ашиглахыг хориглоно.

11.2 дугаар зүйл.Бусдын зан байдлын талаар тодорхойлох

1.Прокурор нь шүүхэд гэрчээр дуудагдсан, Хуульчдын холбооноос даалгасны дагуу хуульчийн талаар эсхүл өөрийн удирдлагад дахь ажилтан, хичээл заадаг оюутныхаа талаар тодорхойлохоос бусад тохиолдолд аливаа этгээдийн зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлохыг хориглоно.

11.3 дугаар зүйл.Олон нийтэд нээлттэй биш мэдээллийг ашиглахгүй байх

1.Прокурор нь прокурорын хувьд олж авсан олон нийтэд нээлттэй биш мэдээллийг албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор задруулах эсхүл ашиглахыг хориглоно.

11.4 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаанд оролцохыг хориглох

1.Прокурор нь энэ дүрмийн 9.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр ялгаварлан гадуурхсан шинжтэй үйл ажиллагаанд оролцох, эсхүл ийм үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гишүүн байхыг хориглоно.

2.Прокурор нь энэ дүрмийн 9.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль нэг эсхүл хэд хэдэн зүйлээр ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа явуулдаг байгууллага гэдгийг мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан бол тухайн байгууллагаас хандив, тусламж авах эсхүл эх үүсвэрийг нь ашиглаж болохгүй.

11.5 дугаар зүйл.Хууль ёсны эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч болох

1.Прокурор нь хамаарал бүхий этгээдийнхээ ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд аливаа этгээдийн хууль ёсны эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч байж болохгүй.

2.Хэрвээ итгэмжлэгдсэн төлөөлөгч прокуророор томилогдвол энэ зүйлийн 1 дэх хэсэгтэй зөрчилдсөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүргээс даруй татгалзана.

11.6 дугаар зүйл.Хөндлөнгийн этгээдийн чиг үүрэг

1.Прокурор нь шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, арбитрч эсхүл бусад хөндлөнгийн этгээдийн хувиар хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхийг хориглоно.

11.7 дугаар зүйл.Хууль зүйн үйлчилгээ

1.Прокурор хууль зүйн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

2.Прокурор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд өөрийгөө өмгөөлж болно.

3.Прокурор нь хамаарал бүхий этгээддээ хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулах, хянах ажиллагаа явуулж болох боловч хамаарал бүхий этгээдийнхээ хуульчаар ажиллаж болохгүй.

11.8 дугаар зүйл.Ашгийн төлөө үйл ажиллагаа

1.Прокурор хуульд зөвшөөрснөөс бусад ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болохгүй.

11.9 дүгээр зүйл.Прокурорын албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлс

1.Прокурор өөрийн хараат бус, зарчимч байдлыг алдагдуулахгүй тохиолдолд хууль болон энэ дүрмээр зөвшөөрсөн албан үүргээс бусад үйл ажиллагаанд хөлс авч болно.

11.10 дугаар зүйл.Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл хүлээн авах, мэдүүлэх

1.Прокурор нь хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, зээл, өв хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авахыг хориглоно.

2.Прокурор албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд саад болох, хараат бус, зарчимч байдлыг нь алдагдуулахуйц эсхүл хуулиар хориглосон аливаа бэлэг, зээл, өв хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл хүлээн авахыг хориглоно.

3.Энэ зүйлийн 1-2 дахь хэсэгт хориглосноос бусад тохиолдолд прокурор нь дараах зүйлсийг мэдүүлэхгүйгээр хүлээн авч болно:

3.1.дурсгалын зүйл, гэрчилгээ, цом, ил захидал зэрэг үнэ багатай зүйлс;

3.2.олон нийттэй адил нөхцөлөөр авч болох санхүүгийн эсхүл худалдааны боломж, хямдрал, үйлчилгээ, зээл, уралдаан, тэмцээний шагнал, тэтгэлэг, хонжвор, сугалаа;

3.3.ном, сэтгүүл, дүрс, дуу бичлэг;

3.4.хуульд өөрөөр заагаагүй бол өөртэй нь хамаарал бүхий этгээдээс өгсөн бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл.

11.11 дүгээр зүйл.Зардлыг нөхөн төлүүлэх ба төлбөрөөс чөлөөлүүлэх

1.Хууль, энэ дүрмийн 11.1 болон 11.10 дугаар зүйлд хориглосноос бусад тохиолдолд прокурор нь энэ дүрэмд зөвшөөрсөн прокурорын албан үүргээс бусад үйл ажиллагаанд оролцохтой холбогдуулан аялал, хоол, байр, бусад зардлыг нөхөн төлүүлж, эсхүл бүртгэл, сургалтын төлбөр, түүнтэй төстэй төлбөрөөс чөлөөлүүлж болно.

2.Прокурорын аялал, хоол, байр эсхүл бусад зардалд өгөх нөхөн төлбөр нь прокурорт өөрт нь болон шаардлагатай тохиолдолд түүний эхнэр буюу нөхөр, хамтран амьдрагч, зочинд зарцуулсан бодит зардлаар хязгаарлагдана.

3.Өөрийн эсхүл эхнэр буюу нөхөр, хамтран амьдрагч, зочныхоо зардлыг нөхөн төлүүлэх эсхүл төлбөрөөс чөлөөлөгдөхийг зөвшөөрсөн прокурор нь энэ дүрмийн 11.12 дугаар зүйлд заасны дагуу энэ талаар мэдүүлнэ.

11.12 дугаар зүйл.Мэдүүлэх үүрэг

1.Прокурор нь дараах хөлс, төлбөрийн хэмжээ эсхүл үнийг мэдүүлнэ:

1.1.энэ дүрмийн 11.9 дүгээр зүйлд зөвшөөрсөн прокурорын албан үүргээс бусад үйл ажиллагааны төлөө авсан хөлс;

1.2.энэ дүрмийн 11.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зөвшөөрсний дагуу нөхөн төлсөн зардал болон чөлөөлсөн төлбөрийн хэмжээ нь дангаараа эсхүл нэг жилд нэг эх сурвалжаас авсан нийлбэрээрээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тухайн төлбөрийн хэмжээ.

2.Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдүүлэгт хөлс хүлээн авсан үйл ажиллагааны огноо, газар болон агуулга, зардлыг нөхөн төлсөн эсхүл төлбөрөөс чөлөөлсөн эх сурвалжийн талаар бичнэ.

3.Прокурор нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргах мэдүүлгийг нэг жилд доод тал нь нэг удаа гаргах бөгөөд нөхөн төлсөн зардал, чөлөөлсөн төлбөрийн тухай мэдүүлгийг тухайн арга хэмжээ эсхүл хөтөлбөр дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргана.

4.Прокурор энэ зүйлд заасан мэдүүлгийг Хуульчдын холбоо болон хуульд заасан холбогдох байгууллагад гаргана. Прокурор нь мэдүүлгээ олон нийтэд нээлттэй болгох талаар чармайн ажиллана.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧТОЙ ХАРИЛЦАХ

12.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчтай харилцах

1.Прокуророос хууль сахиулагчид өгөх чиглэл, даалгавар нь хууль зүйн үндэслэлтэй, тодорхой, ойлгомжтой байна.

2.Прокурор нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль тогтоомж, түүний хэрэглээ, хөгжлийн сэдвээр хууль сахиулагчид зориулсан сургалт зохион байгуулахад оролцож, тусалж болно.

12.2 дугаар зүйл.Яллагдагчтай харилцах

1.Прокурор нь яллагдагчийг зөвхөн буруутгах, доромжлох, дорд үзэх хандлагаар мөрдөн шалгах ажиллагааг чиглүүлж яллаж болохгүй.

2.Хууль сахиулагч яллагдагчид холбогдсон хэргийнх нь талаар мэдэгдсэн эсэх, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо өөрөө эсхүл өмгөөлөгчөөр дамжуулж хамгаалах эрхтэйг нь тайлбарласан эсэхэд прокурор хяналт тавина. Прокурор яллагдагч өмгөөллийн үйлчилгээ авах үндсэн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, энэ талаарх арга хэмжээ авахыг хууль сахиулагчид даалгана.

3.Прокурор яллагдагчтай харилцахдаа түүнд хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа мэт ойлголт төрүүлж болохгүй.

4.Яллагдагч өмгөөлөгчтэйгээ харилцахад нь прокурор үндэслэлгүйгээр саад учруулахыг хориглоно.

5.Прокурор нь хуульд заасан эсхүл өмгөөлөгч нь зөвшөөрснөөс бусад тохиолдолд яллагдагчтай түүний өмгөөлөгчийг нь байлцуулахгүйгээр харилцахыг хориглоно.

12.3 дугаар зүйл.Өөрийгөө өмгөөлж буй яллагдагчтай харилцах

1.Гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа авах эрхээсээ сайн дураараа татгалзсан яллагдагчийг өөрийгөө өмгөөлж буй яллагдагч гэнэ.

2.Прокурор нь өөрийгөө өмгөөлж буй яллагдагчид холбогдсон хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар үнэн мэдээлсэн эсэх, эдлэх эрхийг нь дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн эсэхэд хяналт тавина. Мэдээлэл, тайлбар нь яллагдагчийн эрх зүйн мэдлэггүй байдлыг урвуулан ашигласан, мэхэлсэн, эсхүл гэмт хэргийн хариуцлагаар далайлган сүрдүүлсэн зорилго, хэлбэрийг агуулж болохгүй.

3.Өөрийгөө өмгөөлж буй яллагдагч өмгөөллийн үйлчилгээ авахыг хүсвэл прокурор нэн даруй өмгөөллийн үйлчилгээ авах боломжоор хангана. Шаардлагатай тохиолдолд өмгөөлөгч томилуулах журмыг яллагдагчид танилцуулна.

4.Прокурор нь өөрийгөө өмгөөлж буй яллагдагчаас гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх тодорхой эрхээсээ татгалзсан тухай зөвшөөрөл авах эсхүл авахаар оролдохыг хориглоно.

12.4 дүгээр зүйл.Яллагдагчийн өмгөөлөгчтэй харилцах

1.Прокурорт дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

1.1.яллагдагчийн өмгөөлөгч нотлох баримт цуглуулахад үндэслэлгүй саад учруулах, нотолгооны ач холбогдолтой байж болох баримт бичиг, бусад материалыг хууль бусаар өөрчлөх, устгах, нуун дарагдуулах, эсхүл ийм үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвлөх, туслах;

1.2.нотлох баримт гаргуулах тухай өмгөөлөгчийн хууль ёсны хүсэлтийг биелүүлэхгүй байх.

2.Прокурор яллагдагчийн өмгөөлөгчтэй сөргөлдсөн харилцаатай эсэхээс үл хамааран түүнийг ялгаварлан гадуурхахгүй, мэргэжлийн түвшинд зохих ёсоор харилцана.

3.Прокурор нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд зөвхөн бодит үнэнийг тогтоох болон гэмт хэргийг хуулийн дагуу шударга шийдвэрлэх зорилгоор өмгөөлөгчтэй хамтран ажиллана.

4.Хуульд өөрөөр заагаагүй бол прокурор нь яллагдагчийг цагаатгах, эсхүл ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдалтай холбоотой нотлох баримтыг яллагдагч, түүний өмгөөлөгч болон шүүхэд цаг алдалгүй танилцуулна.

12.5 дугаар зүйл.Хохирогчтой харилцах

1.Хохирогч хуульд заасан эрх, үүрэгтэйгээ танилцсан эсэх, эрхээ эдлэх боломжоор хангагдсан эсэхэд прокурор хяналт тавина.

2.Прокурор нь хохирогчид прокурорын чиг үүрэг болон гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын талаар танилцуулж, түүний эрх, ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх этгээд биш болохоо мэдэгдэнэ.

3.Прокурор яллах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийтийн ашиг сонирхолтой давхацсан хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаална. Прокурор нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хамгаалагдах боломжгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо бусад хянан шийдвэрлэх ажиллагаагаар хамгаалуулах эрхтэй болохыг хохирогчид тайлбарлана.

4.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд прокурор нь хохирогчид туслах дараах арга хэмжээ авна:

4.1.нотлох баримт болгон хураан авсан хохирогчийн эд зүйлийг боломжит тохиолдолд буцаан олгуулах;

4.2.гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийг чирэгдүүлэхгүй, хүнд суртал гаргуулахгүй байхад анхаарах;

4.3.хохирогчид үүсч болох хүндрэл, таагүй нөхцөл байдлаас зайлсхийх;

4.4.шаардлагатай бусад арга хэмжээ.

5.Прокурор нь хохирогчийг хамгаалахын тулд хууль сахиулагчтай дараах байдлаар хамтран ажиллана:

5.1.хохирогчийн хувийн мэдээллийг нууцлах;

5.2.шаардлагатай тохиолдолд хохирогчийг яллагдагч, түүнтэй хамаарал бүхий этгээд, эсхүл хохирогчийн аюулгүй байдалд бодитой эрсдэл учруулахуйц бусад этгээдтэй уулзуулахгүй байх арга хэмжээ авахуулах;

5.3.хохирогчид аюулгүй орчин бүрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авахуулах;

5.4.хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч, түүнтэй хамаарал бүхий этгээдэд учрах аливаа дарамт, заналхийлэл, хүчирхийлэл, өшөө авалтаас сэргийлэх;

5.5.шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийг хамгаалах, туслах хөтөлбөрт хамруулах.

12.6 дугаар зүйл.Гэрчтэй харилцах

1.Прокурор гэрч болон хохирогчид хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадуур яллагдагчийн өмгөөлөгчтэй харилцах, түүнд мэдээлэл өгөхгүй байх эрхийг нь танилцуулж, яллагдагчийн өмгөөлөгчид өгсөн аливаа мэдээллээс үүсэх үр дагаврын талаар тайлбарлаж болох боловч яллагдагчийн өмгөөлөгчтэй уулзахгүй байх эсхүл мэдээлэл өгөхгүй байх талаар зөвлөж болохгүй.

2.Прокурор нь худал мэдүүлэг өгөхийг гэрчид зөвлөх, туслахыг хориглоно.

3.Прокурор нь гэрчид мэдүүлгийн сэдэв, хэлбэр, аргын талаар тайлбарлах бөгөөд гэрч үнэн мэдүүлэг өгөх үүргээ ойлгосон байх талаар шаардлагатай арга хэмжээ авна.

4.Прокурор нь энэ дүрмийн 12.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэрчид туслах арга хэмжээ авах бөгөөд хуульд заасан тохиолдолд гэрчээс гаргасан зардлыг нөхөн төлүүлэхэд анхаарна.

5.Прокурор нь энэ дүрмийн 12.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гэрчийг хамгаалах зорилгоор хууль сахиулагчтай хамтран ажиллана.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭМТ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

13.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа

1.Прокурор мөрдөн шалгах ажиллагааг тасралтгүй явуулахад хяналт тавьж, удирдан чиглүүлнэ.

2.Прокурор нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрхийг зөрчихгүйгээр, хуульд заасан журмаар бүрдүүлсэн нотлох баримтад үндэслэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцлийг хангаж ажиллана.

3.Прокурор нь хүний эрхийг зөрчиж эсхүл хууль бусаар нотлох баримт бүрдүүлэх, бусдад тийнхүү даалгах, бусдын тийм үйлдлийг дэмжихийг хориглоно.

4.Гэмт хэргийн шинжид хамаарахаас бусад тохиолдолд прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг чиглүүлэхдээ хохирогч, яллагдагчийг энэ дүрмийн 9.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлөөр ялгаварлан гадуурхах, давуу эсхүл сул тал болгож болохгүй.

5.Прокурор нь мөрдөн шалгах ажиллагаа хууль бусаар явагдаж байгаа эсхүл хууль сахиулагч нотлох баримтыг хууль бусаар цуглуулсан тухай мэдвэл энэ талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэх, шалгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээ авна.

13.2 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах

1.Прокурор нь хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах талаар чармайж ажиллана.

2.Прокурор нь хувийн ашиг сонирхлоо тэргүүнд тавих, яллагдагч эрхээ хамгаалахад нь саад учруулах, залхаах, шүүхийг мэхлэх зэргээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах эсхүл хойшлуулахыг хориглоно.

13.3 дугаар зүйл.Үнэнийг мэдүүлэх

1.Прокурорт дараах санаатай үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

- 1.1.шүүхэд үйл баримтын талаар худал мэдээлэл өгөх;
- 1.2.нотлох баримтын агуулгыг гуйвуулан тайлбарлах, хуурамч нотлох баримтыг зориуд гаргаж өгөх;
- 1.3.урьд нь шүүхэд өгсөн үйл баримтын талаарх мэдээлэл эсхүл нотлох баримт нь худал гэдгийг мэдсэн боловч энэ тухай шүүхэд мэдэгдэх зэрэг зөвтгөх арга хэмжээ авахгүй байх.

2.Хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж байгаа, үйлдэж байгаа, эсхүл үйлдсэн тухай баттай мэдсэн бол прокурор эрх бүхий байгуулагад мэдэгдэх, шалгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээ авна.

13.4 дүгээр зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг сахих

1.Прокурор хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүгчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлнэ.

2.Прокурорт дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

- 2.1.шүүгч эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид хуулиар хориглосон аргаар нөлөөлөх эсхүл нөлөөлөхийг оролдох;
- 2.2.хуульд эсхүл энэ дүрэмд зөвшөөрснөөс бусад тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчтэй яллагдагчийн өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр харилцах;
- 2.3.шүүгчтэй үүссэн хувийн харилцаагаа давуу байдал болгох замаар хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх;
- 2.4.хэрэгт ач холбогдолгүй эсхүл нотлох баримтгүй зүйлээр хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах;
- 2.5.үйл баримтын талаар эсхүл яллагдагчийн гэм буруутай эсэх талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх.

13.5 дугаар зүйл.Шүүх эрх мэдэл болон шүүгчид хүндэтгэлтэй хандах

1.Прокурор нь шүүх эрх мэдэл болон шүүгчид хүндэтгэлтэй хандана. Энэхүү үүрэг нь прокурорын зүгээс шүүх болон шүүгчийг үндэслэлтэйгээр шүүмжлэх эрхийг хязгаарлахгүй.

2.Прокурор нь хуульд болон энэ дүрэмд заасан үндэслэл байгаа тохиолдолд тухайн шүүгчээс татгалзах үүргээс зайлсхийж болохгүй.

13.6 дугаар зүйл. Ял эдлүүлэх ажиллагаа

1. Прокурор нь ял эдлүүлэх, ялаас чөлөөлөх, өршөөл үзүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, ялтаны эрхийг хангахад хяналт тавьж ажиллана.

2. Прокурор нь ялтны гэм буруугүйг нотлох магадлалтай шинэ нотлох баримтыг мэдсэн бол энэ талаар тухайн ялтан, түүний өмгөөлөгч болон шүүхэд нэн даруй мэдэгдэнэ.

3. Прокурор өөрийн ялласан ялтны гэм бурууг үгүйсгэсэн нотлох баримтыг мэдсэн бол тухайн ялтанд ял ногдуулсан шүүхийн шийдвэрийг зөвтгөх талаар шүүх болон зохих байгууллагад мэдэгдэнэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ПРОКУРОРЫН УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

14.1 дүгээр зүйл. Улс төрийн үйл ажиллагаанд баримтлах ерөнхий зарчим

1. Прокурор өөрийн албан үүргээ бодитой, шударгаар хэрэгжүүлэх, хараат бус, зарчимч байдалд нь харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцож болохгүй.

14.2 дугаар зүйл. Прокурорт улс төрийн үйл ажиллагааг хориглох

1. Улс төрийн байгууллага гэдэгт улс төрийн нам, эсхүл улс төрийн нам, нэр дэвшигчээс санхүүжүүлсэн, зохион байгуулсан бөгөөд улс төрийн албан тушаалд нэр дэвшигчийг сонгуулах, томилуулах зорилго бүхий нэгдлийг ойлгоно.

2. Хуульд зөвшөөрснөөс бусад тохиодолд прокурорт дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

2.1. улс төрийн байгууллагад манлайлах үүрэг гүйцэтгэх, гишүүн байх эсхүл албан тушаал хаших;

2.2. улс төрийн байгууллагын нэрийн өмнөөс илтгэл тавих, үг хэлэх;

2.3. нийтийн албан тушаалд нэр дэвшигчийг олон нийтийн өмнө дэмжих эсхүл эсэргүүцэх;

2.4. улс төрийн байгууллага эсхүл нийтийн албан тушаалд нэр дэвшигчийн төлөө хандив өгөх, энэ талаар уриалах, тандах судалгаа эсхүл бусад үнэлгээний ажлын төлбөрийг төлөх;

2.5. улс төрийн байгууллага эсхүл нийтийн албан тушаалд нэр дэвшигчийн санхүүжүүлсэн арга хэмжээнд мэдсээр байж оролцох;

2.6. улс төрийн байгууллагын нэр дэвшигч гэж олон нийтэд өөрийгөө тодорхойлох;

2.7. улс төрийн байгууллагаас аливаа дэмжлэг, хандив хүсэх, хүлээн авах, ашиглах.

3. Прокурор өөрийнх нь нэрийн өмнөөс бусад этгээд энэ зүйлийн 2 дахь хэсэгт хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

14.3 дугаар зүйл. Албан тушаалд нэр дэвших

1. Прокурор хуулиар зөвшөөрснөөс бусад албан тушаалд нэр дэвшсэн тохиолдолд прокурорын бүрэн эрхээ дуусгавар болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ ШҮҮГЧ

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БИЕ ДААСАН, ЗАРЧИМЧ, ТӨВИЙГ САХИХ БАЙДАЛ

15.1 дүгээр зүйл.Хууль биелүүлэх, хэрэглэх

1.Шүүгч нь хууль болон энэ дүрмийг биелүүлнэ.

2.Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль болон шударга ёсонд захирагдаж, хуулийг хэрэглэнэ.

15.2 дугаар зүйл.Шүүх эрх мэдэлд итгэх итгэлийг хадгалах, дэмжих

1.Шүүгч нь шүүх эрх мэдлийн бие даасан, зарчимч, төвийг сахих зарчмыг чанд баримтлах бөгөөд эдгээр зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.

2.Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд тийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ.

15.3 дугаар зүйл.Шүүгчийн нэр хүндийг урвуулан ашиглахгүй байх

1.Шүүгч хувийн ашиг сонирхлоо хангах зорилгоор шүүгчийн албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, эсхүл бусад этгээдэд тийнхүү ашиглахыг зөвшөөрөхийг хориглоно.

15.4 дүгээр зүйл.Төвийг сахих болон шударга байх

1.Шүүгч нь шүүх эрх мэдлийг шударга, төвийг сахиж хэрэгжүүлнэ.

15.5 дугаар зүйл.Тэгш хандах

1.Шүүгч албан үүргээ гүйцэтгэхдээ нас, хүйс, арьсны өнгө, жендэр, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, хөрөнгө чинээ, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн байр суурь зэргээр ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэхийг хориглоно.

2.Шүүгч нь шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хориглосон үйлдэл, эс үйлдэхгүй гаргасныг мэдсэн бол зогсоох арга хэмжээ авна.

3.Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагааны аливаа оролцогчоос энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хориглолтыг зөрчихгүй байхыг шаардана.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл нь хэрэг, маргааны шинжид хамаарах тохиолдолд шүүгч эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос тухайн нөхцөлийг зайлшгүй шаардлагаар дурдсаныг энэ зүйлийн 1-3 дахь хэсгийг зөрчсөнд тооцохгүй.

15.6 дугаар зүйл.Шүүгчийн үйл ажиллагааг гадны нөлөөллөөс хамгаалах

1.Шүүгч нийгэм, улс төр, эдийн засагт үүссэн нөхцөл байдал эсхүл олон нийтийн дургүйцэл, шүүмжлэлд автаж хэрэг, маргааныг шийдвэрлэж болохгүй.

2.Шүүгч нь үйл ажиллагаа явуулахдаа гэр бүл, нийгэм, улс төр, санхүүгийн зэрэг ашиг сонирхлын аливаа нөлөөлөлд автаж болохгүй.

3.Шүүгч аливаа этгээд өөрт нь нөлөөлөх байр суурьтай гэсэн ойлголт төрүүлэх, эсхүл бусад этгээдийн зүгээс тийм ойлголт төрүүлсэн талаар мэдсэн бол залруулах арга хэмжээ авна.

4.Шүүгч нь бусад шүүгчид хэрэг, маргаан шийдвэрлэхтэй холбоотой заавар, чиглэл өгч болохгүй.

5.Шүүгч хэрэг, маргаан шийдвэрлэхдээ дээд шатны эсхүл бусад шүүх, шүүгчээс заавар, чиглэл авах, эсхүл тийм заавар, чиглэлд захирагдаж болохгүй.

6.Шүүгч нь тухайн хэрэг, маргааныг хараат бусаар шийдвэрлэх үүргээ зөрчихгүйгээр бусад шүүгчтэй санал солилцож болно. Энэ заалтын бусад шүүгч гэдэгт тухайн шүүгчийн шийдвэрийг давж заалдах эсхүл хяналтын журмаар хянан шийдвэрлэх шүүгч хамаарахгүй.

7.Тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхтэй нь холбогдуулан биечлэн уулзах, утсаар ярих, биет болон цахим шуудан явуулах зэргээр шүүгчид хөндлөнгөөс нөлөөлсөн эсхүл нөлөөлөхөөр завдсан этгээдийн талаар нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.

15.7 дугаар зүйл.Хэлэлцүүлэх эрхийг хангах

1.Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдсөн аливаа этгээд эсхүл түүний хуульчид хэрэг, маргаанаа хэлэлцүүлэх эрхийг тэгш хангана.

2.Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагааны талууд болон тэдгээрийн хуульчийг хэрэг, маргаанаа эвлэрэн шийдвэрлэх талаар зөвлөн дэмжиж болох боловч дарамт үзүүлж болохгүй.

15.8 дугаар зүйл.Хэрэг, маргааныг шийдвэрлэх

1.Хуульд эсхүл энэ дүрмийн 16.1-16.3 дугаар зүйлд заасны дагуу татгалзсанаас бусад тохиолдолд шүүгч нь хэрэг, маргааныг заавал шийдвэрлэнэ.

15.9 дүгээр зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээг сахиулах ба биеэ зөв авч явах

1.Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүх хуралдаанд оролцогчоос хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, шүүх хуралдааны дэг, журмыг сахиыхыг шаардана.

2.Шүүгч нь хэргийн оролцогч, иргэдийн төлөөлөгч, шүүхийн ажилтан, болон албан үүргийн дагуу харилцаж байгаа бусад этгээдтэй хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцах бөгөөд тэдгээрээс мөн адил харилцахыг шаардана.

15.10 дугаар зүйл.Хэрэг, маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах

1.Дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгч өөрийн шийдвэрлэх хэрэг, маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, тийм санаачлага гаргах, зөвшөөрөхийг хориглоно:

1.1.нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцсанаар нөгөө тал хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд давуу байдал олж авахгүй гэдэгт шүүгч үндэслэлтэйгээр итгэж байгаа бөгөөд нөгөө талтай харилцсан харилцааны агуулгыг бүх талуудад даруй мэдэгдэж хариу өгөх боломж олгосон тохиолдолд тухайн хэрэг, маргааны агуулгатай холбогдолгүй захиргааны, шүүх хуралдааны бэлтгэл хангах, тов тогтоох зэрэг асуудлаар нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцаж болно;

1.2.талууд мэдээлэлтэй зөвшөөрөл өгсөн тохиолдолд шүүгч нь шийдвэрлэх гэж байгаа асуудлыг эвлэрүүлэн шийдвэрлэх зорилгоор талууд болон тэдний хуульчидтай дангаар нь уулзаж болно. Эвлэрүүлэн шийдвэрлэх ажиллагаа үр дүнд хүрээгүй тохиолдолд уг ажиллагаанд оролцсон шүүгч тухайн асуудлыг шийдвэрлэх шүүгчээр ажиллахгүй;

1.3.хуульд заасан тохиолдолд шүүгч нь нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцаж болно.

2.Хэрэв шүүгч нь хэрэг, маргааны агуулгатай холбогдуулан нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай санамсаргүй харилцсан бол тухайн харилцааны агуулгыг нэг талд даруй мэдэгдэж хариу өгөх боломж олгоно.

3.Хуульд зааснаас бусад тохиолдолд шүүгч нь хэрэг, маргааны үйл баримтыг өөрийн санаачлагаар шалгаж болохгүй бөгөөд зөвхөн талуудын гаргаж өгсөн нотлох баримтыг үнэлж, хэргийг шийдвэрлэнэ.

4.Шүүгч нь шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдийн зүгээс энэ зүйлд заасан шаардлагуудыг зөрчихгүй байх талаар шаардлага тавьж ажиллана.

15.11 дүгээр зүйл.Шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хэрэг, маргааны талаар мэдээлэх

1.Дор дурдсанаас бусад тохиолдолд шүүгч нь шүүхэд шийдвэрлэгдэх гэж байгаа эсхүл шийдвэрлэгдэх магадлалтай хэрэг, маргааны талаар олон нийтэд мэдээлэл хийхийг хориглоно:

1.1.хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэхэд саад болохгүй, эсхүл үр дүнд нөлөөлөхгүй хэмжээнд хичээл заах, судалгааны ажил хийх, өгүүлэл, ном бичих, илтгэл тавих зэргээр мэдээлэл хийх;

1.2.тодорхой хэрэг, маргаантай холбогдолгүйгээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тайлбарлах;

1.3.олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл эсхүл бусад арга замаар өөрийнх нь үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан буруутгалд хариу өгөх;

1.4.өөрөө хувь хүнийхээ хувьд хэргийн оролцогчоор оролцож байгаа хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар хийх.

2.Шүүгч шүүхэд хянан шийдвэрлэгдэх боломжтой хэрэг, маргаантай холбогдуулан албан үүргээ шударгаар, төвийг сахиж хэрэгжүүлэхэд харшлах аливаа амлалт өгөхийг хориглоно.

3.Шүүгч нь шүүхийн ажилтан эсхүл өөрийн удирдлага дахь бусад этгээд энэ зүйлийн 1-2 дахь хэсэгт хориглосон мэдээлэл, амлалт хийхээс татгалзахыг шаардана.

4.Шүүгч нь хэрэг, маргааны оролцогч гэдгийг мэдсээр байж түүнтэй олон нийтийн цахим сүлжээгээр харилцахыг хориглоно.

АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

16.1 дүгээр зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ерөнхий нөхцөл

1.Шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана.

2.Шүүгч дараах нөхцөл үүссэн тохиолдолд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

2.1.шүүгч өөрөө эсхүл өөртэй нь хамаарал бүхий этгээд тухайн маргаантай асуудалд эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг талтай хувийн ашиг сонирхлоор холбоотой гэдгийг мэдэж байгаа;

2.2.тухайн хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлын талаар тодорхой үр дүнд хүрнэ, шийдвэр гаргана гэж олон нийтэд мэдээлсэн эсхүл олон нийтэд тийм ойлголт төрүүлсэн.

16.2 дугаар зүйл.Хянан шийдвэрлэх ажиллагааны оролцооноос шалтгаалж татгалзах

1.Шүүгч нь өөрөө эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нь дараах этгээдийн аль нэг гэдгийг мэдсэн бол тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

- 1.1.хэрэг, маргааны оролцогч, эсхүл түүний шууд удирдах албан тушаалтан;
- 1.2.хуульчаар оролцож байгаа;
- 1.3.гэрчээр оролцох.

16.3 дугаар зүйл.Урьд нь гүйцэтгэж байсан үүргээс хамаарч татгалзах

1.Шүүгч урьд нь тухайн хэрэг, маргаантай холбогдуулан дараах үүргийн аль нэгийг гүйцэтгэж байсан бол хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана:

- 1.1.хуульчаар оролцож байсан, эсхүл нэг өмгөөллийн нөхөрлөлд ажиллаж байсан бусад хуульч нь тухайн асуудалд голлох үүрэгтэй оролцсон;
- 1.2.хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн албан хаагчийн хувиар оролцсон эсхүл тухайн асуудлын талаар төрийн албан хаагчийн хувьд байр сууриа олон нийтэд илэрхийлж байсан;
- 1.3.гэрчийн мэдүүлэг өгч байсан;
- 1.4.хянан шийдвэрлэхэд шүүгчээр оролцож байсан.

16.4 дүгээр зүйл.Ашиг сонирхол, хөрөнгө, орлогоо мэдүүлэх

1.Шүүгч нь өөрийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тогтмол, үнэн, зөв мэдүүлж, манлайлна.

16.5 дугаар зүйл.Талууд болон тэдгээрийн хуульчид шүүгчээс татгалзах

1.Шүүгч энэ дүрмийн 16.1-16.3 дугаар зүйлд зааснаар хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах үндэслэл байгаа бол энэ талаар талуудад мэдэгдэх бөгөөд тэдгээрийг шүүгчээс татгалзах санал тавих боломжоор хангана.

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН АЛБАН ҮҮРГЭЭС БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ХУВИЙН АМЬДРАЛ

17.1 дүгээр зүйл.Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаа

1.Шүүгч хууль эсхүл энэ дүрэмд хориглосноос бусад тохиолдолд шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаанд оролцож болно.

2.Шүүгч шүүгчийн албан үүргээс бусад дараах агуулга бүхий үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

- 2.1.шүүгчийн үүргээ зохистой хэрэгжүүлэхэд саад болохуйц;
- 2.2.энэ зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын улмаас хэргийн оролцогчийн зүгээс шүүгчээс татгалзахад хүргэх;
- 2.3.шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулах
- 2.4.хүч хэрэглэсэн мэт ойлгогдох.

3.Шүүгч шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь бусад этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг, даалгавар өгч болохгүй.

4.Шүүгч нь хуулиар зөвшөөрсөн, эсхүл шүүгчийн албан үүрэг, шүүхийн захиргаа, хууль зүйн хөгжил, боловсролтой холбоотойгоос бусад зорилгоор шүүхийн байр, техник, санхүү, мэдээллийн хэрэгсэл, бичиг хэрэг эсхүл бусад эх үүсвэрийг ашиглахыг хориглоно.

17.2 дугаар зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтантай зөвлөлдөх

1.Дор дурдсан аль нэг нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд шүүгч нь гүйцэтгэх эсхүл хууль тогтоох эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтантай зөвлөлдөх, эсхүл тэдний зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

1.1.шүүхийн захиргааг хэрэгжүүлэх;

1.2.Хуульчдын холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

1.3.шүүгчийн мэдлэг, ур чадварыг ашиглах;

1.4.шүүгч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх.

17.3 дугаар зүйл.Бусдын зан байдлын талаар тодорхойлох

1.Шүүгч нь шүүхэд гэрчээр дуудагдсан, Хуульчдын холбооноос даалгасны дагуу хуульчийн талаар эсхүл өөрийн удирдлага дахь ажилтаны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд бусад хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлохыг хориглоно.

17.4 дүгээр зүйл.Олон нийтэд нээлттэй биш мэдээллийг ашиглахгүй байх

1.Шүүгч нь шүүгчийн хувьд олж авсан олон нийтэд нээлттэй биш мэдээллийг албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор задруулах эсхүл ашиглахыг хориглоно.

17.5 дугаар зүйл.Ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаанд оролцохыг хориглох

1.Шүүгч нь энэ дүрмийн 15.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ялгаварлан гадуурхсан шинжтэй үйл ажиллагаанд оролцох, эсхүл тийм үйл ажиллагаа явуулдаг байгууллагад гишүүн байхыг хориглоно.

2.Шүүгч нь энэ дүрмийн 15.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль нэг эсхүл хэд хэдэн нөхцөлөөр ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа явуулдаг байгууллага гэдгийг мэдсэн эсхүл мэдэх ёстой байсан бол тухайн байгууллагаас үзүүлсэн хандив, тусламж эсхүл эх үүсвэрийг ашиглаж болохгүй.

17.6 дугаар зүйл.Хууль ёсны эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч болох

1.Шүүгч нь хамаарал бүхий этгээдийнхээ ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд аливаа этгээдийн хууль ёсны эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч байж болохгүй.

2.Хэрвээ итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүгчээр томилогдвол энэ зүйлийн 1 дэх хэсэгтэй зөрчилдсөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүргээс даруй татгалзана.

17.7 дугаар зүйл.Хөндлөнгийн этгээдийн чиг үүрэг

1.Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд шүүгч нь шүүгчийн албан үүргээс гадна эвлэрүүлэн зуучлагч, арбитрч эсхүл бусад хөндлөнгийн этгээдийн хувиар хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхийг хориглоно.

17.8 дугаар зүйл.Хууль зүйн үйлчилгээ

1.Шүүгч хууль зүйн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

2.Шүүгч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд өөрийгөө өмгөөлж болно.

3.Шүүгч нь хамаарал бүхий этгээддээ хууль зүйн зөвлөгөө өгөх, баримт бичиг боловсруулах, хянах ажиллагаа явуулж болох боловч хамаарал бүхий этгээдийнхээ хуульчаар ажиллаж болохгүй.

17.9 дүгээр зүйл.Ашгийн төлөө үйл ажиллагаа

1.Шүүгч хуульд зөвшөөрснөөс бусад ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болохгүй.

17.10 дугаар зүйл.Шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны хөлс

1.Шүүгч өөрийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулахгүй тохиолдолд хууль болон энэ дүрмээр зөвшөөрсөн шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаанд хөлс авч болно.

17.11 дүгээр зүйл.Бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл хүлээн авах, мэдүүлэх

1.Шүүгч нь хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, зээл, өв хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авахыг хориглоно.

2.Шүүгч нь шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулах эсхүл хуулиар хориглосон аливаа бэлэг, зээл, өв хөрөнгө, хандив, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл хүлээн авахыг хориглоно.

3.Хууль эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт хориглосноос бусад тохиолдолд шүүгч нь дараах зүйлсийг мэдүүлэхгүйгээр хүлээн авч болно:

3.1.дурсгалын зүйл, гэрчилгээ, цом, ил захидал зэрэг үнэ багатай зүйлс;

3.2.олон нийттэй адил нөхцөлөөр авч болох санхүүгийн эсхүл худалдааны боломж, хямдрал, үйлчилгээ, зээл, уралдаан, тэмцээний шагнал, тэтгэлэг, хонжвор, сугалаа;

3.3.ном, сэтгүүл, дүрс, дуу бичлэг;

3.4.хуульд өөрөөр заагаагүй бол энэ дүрмийн 16.1-16.3 дугаар зүйлд заасны дагуу шүүгчийг татгалзахад хүргэх этгээдээс өгсөн бэлэг, зээл, өв хөрөнгө, үйлчилгээ эсхүл бусад үнэ бүхий зүйл.

17.12 дугаар зүйл.Зардлыг нөхөн төлүүлэх ба төлбөрөөс чөлөөлүүлэх

1.Хууль, энэ дүрмийн 17.1 болон 17.11 дүгээр зүйлд хориглосноос бусад тохиолдолд шүүгч нь энэ дүрэмд зөвшөөрсөн шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагаанд оролцохтой холбогдуулан аялал, хоол, байр, бусад зардлыг нөхөн төлүүлж, эсхүл бүртгэл, сургалтын төлбөр, түүнтэй төстэй төлбөрөөс чөлөөлүүлж болно.

2.Шүүгчийн аялал, хоол, байр эсхүл бусад зардалд өгөх нөхөн төлбөр нь шүүгчид өөрт нь болон шаардлагатай тохиолдолд түүний эхнэр буюу нөхөр, хамтран амьдрагч, зочинд зарцуулсан бодит зардлаар хязгаарлагдана.

3.Өөрийн эсхүл эхнэр буюу нөхөр, хамтран амьдрагч, зочныхоо зардлыг нөхөн төлүүлэх эсхүл төлбөрөөс чөлөөлөгдөхийг зөвшөөрсөн шүүгч нь энэ дүрмийн 17.13 дугаар зүйлд заасны дагуу энэ талаар мэдүүлнэ.

17.13 дугаар зүйл.Мэдүүлэх үүрэг

1.Шүүгч нь дараах хөлс, төлбөрийн хэмжээ эсхүл үнийг мэдүүлнэ:

1.1.энэ дүрмийн 17.10 дугаар зүйлд зөвшөөрсөн шүүгчийн албан үүргээс бусад үйл ажиллагааны төлөө авсан хөлс;

1.2.энэ дүрмийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зөвшөөрсний дагуу нөхөн төлсөн зардал болон чөлөөлсөн төлбөрийн хэмжээ нь дангаараа эсхүл нэг жилд нэг эх сурвалжаас авсан нийлбэрээрээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд тухайн төлбөрийн хэмжээ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу олон нийтэд мэдүүлэх шаардлагатай бол шүүгч нь хөлс хүлээн авсан үйл ажиллагааны огноо, газар болон агуулга зардлыг нөхөн төлсөн эсхүл төлбөрөөс чөлөөлсөн эх сурвалжийн талаар мэдүүлнэ.

3.Шүүгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргах мэдүүлгийг нэг жилд доод тал нь нэг удаа гаргах бөгөөд нөхөн төлсөн зардал, чөлөөлсөн төлбөрийн тухай мэдүүлгийг тухайн арга хэмжээ эсхүл хөтөлбөр дууссанаас хойш 30 хоногийн дотор гаргана.

4.Шүүгч энэ зүйлд заасан мэдүүлгийг Хуульчдын холбоо, тухайн шүүгчийн ажилладаг шүүхийн тамгын газар болон хуульд заасан бусад холбогдох байгууллагад гаргана. Шүүгч нь мэдүүлгээ олон нийтэд нээлттэй болгох талаар чармайн ажиллана.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

18.1 дүгээр зүйл.Улс төрийн үйл ажиллагаанд баримтлах ерөнхий зарчим

1.Шүүгч нь шүүх эрх мэдлийн бие даасан, зарчимч байх, төвийг сахих байдалд харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцож болохгүй.

18.2 дугаар зүйл.Шүүгч болон шүүгчид нэр дэвшигчид улс төрийн үйл ажиллагааг хориглох

1.Хуульд зөвшөөрснөөс бусад тохиодолд шүүгч эсхүл шүүгчид нэр дэвшигчид дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

1.1.улс төрийн байгууллагад манлайлах үүрэг гүйцэтгэх, гишүүн байх эсхүл албан тушаал хаших;

1.2.улс төрийн байгууллагын нэрийн өмнөөс илтгэл тавих, үг хэлэх;

1.3.нийтийн албан тушаалд нэр дэвшигчийг олон нийтийн өмнө дэмжих эсхүл эсэргүүцэх;

1.4.улс төрийн байгууллага эсхүл нийтийн албан тушаалд нэр дэвшигчийн төлөө хандив өгөх, энэ талаар уриалах, тандах судалгаа эсхүл бусад үнэлгээний ажлын төлбөрийг төлөх;

1.5.улс төрийн байгууллага эсхүл нийтийн албан тушаалд нэр дэвшигчийн санхүүжүүлсэн арга хэмжээнд оролцох;

1.6.улс төрийн байгууллагын нэр дэвшигч гэж олон нийтэд өөрийгөө тодорхойлох;

1.7.улс төрийн байгууллагаас аливаа дэмжлэг, хандив хүсэх, хүлээн авах, ашиглах.

2.Шүүгч эсхүл шүүгчид нэр дэвшигч өөрийнх нь нэрийн өмнөөс бусад этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

3.Шүүгчид нэр дэвшигч нь бусад этгээдтэй харилцахдаа шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааныг шударгаар шийдвэрлэхэд саад болох эсхүл үр дүнд нөлөөлөх боломжтой мэдээлэл олон нийтэд хийх, эсхүл шүүхээр шийдвэрлэгдэх боломжтой хэрэг, маргаантай холбогдуулан шүүгчийн үүргийг төвийг сахин шударгаар хэрэгжүүлэхэд харшлах аливаа амлалт өгөхийг хориглоно.

18.3 дугаар зүйл.Албан тушаалд нэр дэвших

1.Шүүгч хуулиар зөвшөөрснөөс бусад албан тушаалд нэр дэвшсэн тохиолдолд шүүгчийн бүрэн эрхээ дуусгавар болгоно.

ТАВДУГААР АНГИ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЗАРЧИМЧ БАЙДАЛ

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬЧ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ

19.1 дүгээр зүйл.Хуульчдын холбооны албан тушаал, үйл ажиллагаа

1.Хуульчдын холбоо нийтийн эрх зүйн этгээд тул тус холбоонд албан тушаал эрхэлж буй хуульч энэхүү дүрэм төдийгүй нийтийн албан тушаалтантай холбоотой хууль тогтоомжид захирагдана.

2.Хуульч өөрийн мэргэжлийн үүрэгтэйгээ зөрчилдөхгүй тохиолдолд Хуульчдын холбоонд дараах үүргийг гүйцэтгэж болно:

- 2.1.Хуульчдын их хурлын төлөөлөгч;
- 2.2.Ерөнхийлөгч;
- 2.3.Зөвлөлийн гишүүн;
- 2.4.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн;
- 2.5.чиг үүргийн хорооны дарга, гишүүн болон бусад хорооны удирдлага;
- 2.6.бусад албан тушаал.

3.Хуульч өөрийн мэргэжлийн үүрэгтэйгээ зөрчилдөхгүй тохиолдолд Хуульчдын холбооны дараах үйл ажиллагаанд оролцож болно.

- 3.1.хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх;
- 3.2.хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, бодлогын нөлөөлөл хийх;
- 3.3.хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх;
- 3.4.шүүгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулах;
- 3.5.шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэх;
- 3.6.холбоо эсхүл түүний чиг үүргийн хорооноос байгуулагдах ажлын хэсэг, комисст ажиллах;
- 3.7.дүгнэлт гаргах;
- 3.8.Холбоо эсхүл хорооны бусад үйл ажиллагаа.

19.2 дугаар зүйл.Хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцоход баримтлах зарчим, үүрэг

1.Хуульч Хуульчдын холбоонд үүрэг гүйцэтгэх эсхүл түүний үйл ажиллагаанд оролцохдоо хууль болон энэ дүрмийн 1.4 дүгээр зүйлд заасан зарчим болон дараах зарчмыг баримтална:

- 1.1.Хуульчдын холбооноос баталсан дүрэм, журмыг биелүүлэх;
- 1.2.хуульчдын мэргэжлийн нэр хүндийг хамгаалах;
- 1.3.хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 1.4.Хуульчдын холбооны бие даасан байдлыг хангах, хүндлэх;
- 1.5.Хуульчдын холбооны гишүүдийн тэгш эрхийг хангах;
- 1.6.Хуульчдын холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олгосон эрх мэдлийг урвуулан ашиглахгүй байх;
- 1.7.шуурхай байх;
- 1.8.ил тод, нээлттэй байх;
- 1.9.төсөвт хэмнэлттэй байх.

2.Хуульч нь Хуульчдын холбооны үйл ажиллагаанд оролцохдоо дараах үүргийг биелүүлнэ:

- 2.1.Хуульчдын холбооны үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан хууль, энэ дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актаар тогтоосон үүрэг;
- 2.2.хууль болон энэ дүрмээр тогтоосон хуульчийн хүлээх нийтлэг болон тусгай үүрэг;
- 2.3.тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Хуульчдын холбооноос тусгайлан хүлээлгэсэн бусад үүрэг.

3.Хуульчдын холбоонд удирдах албан тушаал хашиж байгаа хуульч эсхүл хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийг удирдан ажиллаж байгаа хуульч нь Хуульчдын холбоонд ажиллаж байгаа хуульчийн зөвшөөрөлгүй этгээдийн үйл ажиллагаа энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

ХОРЬДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨРЧИЛ, ХАРИУЦЛАГА

20.1 дүгээр зүйл.Хуульчдын холбоотой харилцах

1.Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогч, Хуульчдын холбооны гишүүнээр элсэх өргөдөл гаргагч, эсхүл мэргэжлийн хариуцлага хүлээсэн хуульчид дараах санаатай үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

- 1.1.худал мэдээлэл өгөх;
- 1.2.урьд нь өгсөн худал мэдээллийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй байх;
- 1.3.тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх.

20.2 дугаар зүйл.Шүүгч, прокурор, эдгээр албан тушаалд нэр дэвшигчийн тухай мэдээлэл

1.Хуульч нь шүүгч, прокурор эсхүл шүүгч, прокурорын албан тушаалд нэр дэвшигчийн мэдлэг, ур чадвар, зарчимч байдлын талаар худал мэдээлэхийг хориглоно.

2.Шүүгчид нэр дэвшигч нь энэ дүрэмд заасан үүргийг биелүүлнэ.

20.3 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил

1.Мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил (цаашид “зөрчил” гэх) гэдэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж эсхүл энэ дүрмийн заалтыг өөрөө эсхүл бусдын үйл ажиллагаагаар дамжуулан зөрчих, зөрчихөөр завдах, эсхүл бусад этгээд зөрчихөд нь туслах, ятгах үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

20.4 дүгээр зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг мэдэгдэх

1.Хуульч нь бусад хуульч мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан талаар мэдсэн бол тухайн зөрчлийг эрх бүхий этгээдэд мэдэгдэх бөгөөд үндэслэл, нотлох баримт зэргийг гаргаж өгнө.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хуульчийн үүрэг нь энэ дүрмийн 2.5 дугаар зүйлээр хамгаалагдсан мэдээлэл эсхүл хуульчид туслах хөтөлбөрт оролцохдоо олж авсан мэдээллийг задруулахыг шаардахгүй.

3.Хуульч өөртэй нь холбоотой мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг мэдээлсэн хуульчаас өс хонзон авах, заналхийлэх, дарамт үзүүлэхийг хориглоно.

20.5 дугаар зүйл.Хуульчид мэргэжлийн хариуцлага хүлээлгэх зарчим

1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шийтгэл хүлээлгэнэ.

2.Зөрчилд шийтгэл ногдуулахдаа хуульчийн эрхэлж байгаа ажил, албан тушаалаас үл хамааран тэгш, шударга хандах бөгөөд зөрчил, шийтгэл хоорондоо дүйцсэн байх зарчмыг удирдлага болгоно.

3.Зөрчилд шийтгэл ногдуулахдаа дараах хүчин зүйлийг харгалзана:

3.1.зөрчлийн хүрээ;
3.2.учруулсан хор уршгийн хэмжээ;
3.3.гэм буруугийн хэлбэр;
3.4.зөрчлийн шалтгаан, нөхцөл байдал;
3.5.сүүлийн 12 сарын дотор шийтгэл хүлээсэн эсэх;
3.6.зөрчил нь хуулийн засаглал, шүүх эрх мэдэл, болон хуульчийн мэргэжилд итгэх олон нийтийн итгэлд нөлөөлөх байдал;
3.7.хуульч гаргасан зөрчилдөө чин санаанаас гэмшсэн буюу зөрчлөө сайн дураар илчлэн ирсэн;
3.8.Хуульчдын холбооноос хэрэгжүүлж буй чиг үүргийг хувьдаа урвуулсан байдал.

4.Зөрчил гаргасан нь бүрэн нотлогдоогүй бол шийтгэл ногдуулахыг хориглоно.

5.Энэ дүрмээр тодорхойлсон зөрчилд хариуцлагын үндсэн хэлбэрүүдээс давхардуулан ногдуулж болохгүй.

6.Нэг зөрчилд зөвхөн нэг удаа шийтгэл ногдуулна.

7.Хуульч гаргасан зөрчилдөө хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэх нь энэ дүрмийн дагуу шийтгэл ногдуулахаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.Мэргэжлийн хариуцлагын хороо энэ дүрмийг зөрчсөн эсэх маргааныг Зөвлөл баталсан маргаан хянан шийдвэрлэх журмын дагуу шийдвэрлэнэ.

9.Хуульч нь Мэргэжлийн хариуцлагын хорооноос шаардсан тохиолдолд үнэн, бүрэн мэдээлэл өгнө.

20.6 дугаар зүйл.Мэргэжлийн хариуцлага хүлээсэн этгээдэд хориглох зүйл

1.Хуульч өөрийнх нь мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон этгээдээс өс хонзон авах, заналхийлэх, дарамт үзүүлэхийг хориглоно.

2.Шүүхэд төлөөлөх эрхээ түдгэлзүүлсэн байх хугацаандаа хуульч нь шүүхэд төлөөлөхийг хориглоно.

3.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзсэн эсхүл хүчингүй болсон бол тухайн үйл ажиллагааг эрхлэх, хуульч нэрийг хэрэглэхийг хориглоно.

4.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзсэн этгээд энэ дүрэмд захирагдна.

--oOo--